

АНУ-ЫН ХӨНГӨЛӨЛТИЙН ЕРӨНХИЙ СИСТЕМ (GSP)

ГАРЫН АВЛАГА

**АНУ-ын Худалдааны төлөөлөгчийн газар
Ерөнхийлөгчийн ажлын алба
Вашингтон, Д. С.**

2007 оны 2-р сар

ГАРЧИГ

Өмнөх үг	3
Товчилсон үгсийн тайлбар	4
ХЕС-ийн Мэдээллийн төв	5
ХЕС -ийн талаар ихэвчлэн тавьдаг асуултууд	6
ХЕС -д хамаарах улс орнууд ба бараа бүтэгдэхүүний талаарх мэдээлэл ба ХЕС -д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай журам	16
ХЕС -ээс ашиг хүртэх эрхтэй улс орон	16
ХЕС –д хамрагдах орнуудад тавигдах шалгуур	19
1995 оны 1-р сарын 1-ний өдрийн байдлаар АНУ-д үйлдвэрлэгдээгүй байсан бараа бүтээгдэхүүний нэр төрөл	21
Өрсөлдөөнт өрсөлдөөнт хэрэгцээний хязгаарлалтаас чөлөөлөгддөг бараа бүтээгдэхүүний нэр төрөл буюу улс орнууд	22
Ашиг хүртэгч улсын ХЕС-д хамаарахгүй бараа бүтээгдэхүүний нэр төрөл	26
ХЕС-д хамрагдах хүсэлт гаргахтай холбоотой мэдээлэл	26
Мэдээллийн бусад эх сурвалжууд	31

ӨМНӨХ ҮГ

АНУ-ын Хөнгөлөлтийн Ерөнхий Систем (ХЕС) буюу GSP нь хөгжиж буй орнуудын эдийн засгийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн хөтөлбөр бөгөөд нэн буурай хөгжилтэй хөгжиж буй 43 орныг оролцуулан 134 улс ба нутаг дэвсгэрээс 3,400 иэр төрлийн бараа, бүтээгдэхүүнийг гаалийн татваргүйгээр тус улсын хилээр оруулах давуу эрх олгодог. ХЕС-ийн хөтөлбөрийг анх 1976 оны 1-р сарын 1-ний өдрөөс хэрэгжүүлж эхэлсэн ба 1974 оны Худалдааны хуульд (19 USC-ийн 2461-р зүйлээс хойш үргэлжлэх) заасны дагуу 10 жилийн хугацаанд хүчинтэй байхаар зохицуулжээ. Тэр үеэс хойш уг хөтөлбөрийг тогтмол шинэчилж ирсэн бөгөөд Ерөнхийлөгч Буш 2008 оны 12-р сарын 31-ний өдрийг дуусталх хугацаанд сунгах хууль тогтоомжид гарын үсэг зурснаар түүнийг хамгийн сүүлд 2006 онд шинэчилсэн байна.

Энэхүү Гарын авлагын зорилго бол ХЕС-ийг болон түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой үндсэн баримт бичгүүдэд агуулагдах мэдээллийг нийтд таниулах явдал юм. Дүрэм ба хэрэгжүүлэх баримт бичгүүд нь шууд хөдөлбөргүй даган биелүүлэх эрх зүйн хэм хэмжээ тогтоосон акт юм. АНУ-ын ХЕС-ийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлж буй хууль тогтоомжийг 19 USC-ийн 2461-2467-ээс буюу АНУ-ын Худалдааны төлөөлөгчийн газрын вэб сайт (<http://www.ustr.gov>)-aac тус тус үзэж болно. АНУ-ын Худалдааны төлөөлөгчийн газрын ХЕС-ийн талаархи хууль тогтоомжийг 15 CFR-ийн 2007-р хэсгээс, эсвэл тус газрын вэб сайтаас тус тус үзэх боломжтой. Дотоодын Аюулгүй Байдлын департаментийн АНУ-ын Гаалийн болон Хилийн хамгаалалтын албаны ажилд хамаарах ХЕС-ийн талаархи хууль тогтоомжийг 19 CFR-ийн 10.171-10.178-р хэсгүүдээс олж үзнэ үү. Түүнчлэн ХЕС-ийн хөтөлбөрт хамрагдаж буй импортлогчид болон экспортлогчдод тустай олон чухал баримт бичгийг Гаалийн алба <http://www.cbp.gov> хаягаарх вэб сайтдаа тавьж үзүүлсэн байгаа.

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ТАЙЛБАР

Англи	Монгол
AGOA (African Growth and Opportunity Act)	(АӨХНБТХ) Африкийн өсөлт хөгжил, нөөц боломжийн тухай хууль
ASEAN (Association of Southeast Asian Nations)	(АСЕАН) Зүүн Өмнөд Азийн улсуудын холбоо
BDC (Beneficiary Developing Country)	(АХХБО) Ашиг хүртэгч хөгжиж буй орон
CARICOM (Caribbean Common Market)	(КН33) Карибийн нэгдсэн зах зээл
CFR (Code of Federal Regulations)	(ХДЖК) Холбооны дүрэм, журмын код
CNL (Competitive Need Limitations)	(ХХ) Өрсөлдөөнт хэрэгцээний хязгаарлалт
EAC (Tripartite Commission on East African Cooperation)	(ЗАХАГТК) Зүүн Африкийн хамтын ажиллагааны гурван талт комисс
GATT (General Agreement on Tariffs and Trade)	(ГАТТ) Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээр
GDP (Gross Domestic Product)	(ДНБ) Дотоодын нийт бүтээгдэхүүн
GNP (Gross National Product)	(ҮНБ) Үндэсний нийт бүтээгдэхүүн
GSP (U.S. Generalized System of Preferences)	(ХЕС) АНУ-ын Хөнгөлөлтийн Ерөнхий Систем
HTSUS (Harmonized Tariff Schedule of the United States)	(БУС) АНУ-ын Барааны уялдуулсан систем
IBRD (International Bank for Reconstruction and Development (World Bank))	(ОУСБХБ) Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк буюу Дэлхийнх Банк
IMF (International Monetary Fund)	(ОУВС) Олон улсын валютийн сан
LDBDC (Least Developed Beneficiary Developing Country)	(НБХХБАХО) Нэн буурай хөгжилтэй хөгжиж буй ашиг хүртэгч орон
MFN (Most Favored Nation (now NTR))	(НТН) Нэн Тааламжтай Нөхцөл (одоо ХЕХ болсон)
NTR (Normal Trade Relations)	(ХЕХ) Худалдааны ердийн харилцаа
OMB (Office of Management and Budget)	(УТАХА) Удирдлага, төсвийн асуудал хариуцсан алба
SAARC (South Asian Association for Regional Cooperation)	(БНХАӨАХ) Бүс нутгийн хамтын ажиллагааны Өмнөд Азийн холбоо
SADC (Southern African Development Community)	(ӨАХХН) Өмнөд Африкийн хөгжлийн хамтын нийгэмлэг
SPI (Special Program Indicator)	(ТХТТ) Тусгай хөтөлбөрийг тодорхойлогч тэмдэг
TPRG (Trade Policy Review Group)	(ХБХШБ) Худалдааны бодлогын хяналт шалгалтын бүлэг
TPSC (Trade Policy Staff Committee)	(ХБАХАХ) Худалдааны бодлогын асуудал хариусан ажилтнуудын хороо
USAID (U.S. Agency for	(АНУОУХА) АНУ-ын Олон улсын

International Development)	хөгжлийн агентлаг
USC (U.S. Code)	АНУ-ын хууль
USITC (U.S. International Trade Commission)	(АНУОУХК) АНУ-ын Олон улсын худалдааны комисс
USTR (U.S. Trade Representative)	(АНУХТГ) АНУ-ын Худалдааны төлөөлөгчийн газар
WAEMU (West African Economic and Monetary Union)	(БАЭЗВХ) Баруун Африкийн здийн засаг, валютийн холбоо
WTO (World Trade Organization)	(ДХБ) Дэлхийн худалдааны байгууллага

ХЕС-ИЙН ХӨТӨЛБӨРИЙН МЭДЭЭЛЛИЙН ТӨВ

ХЕС-ийн Хөтөлбөрийн Мэдээллийн төвийн байршил:

АНУ-ын Худалдааны төлөөлөгчийн газар
1724 Ф Гудамж, Н. В.,
Вашингтон, Д. С. 20508
Утас: (202) 395-6971
Факс: (202) 395-9481
И-мэйл: contactustr@ustr.eop.gov

Нийтэд зориулсан баримт бичгийг:

АНУХТГ-ын Нийтийн уншлагын танхим
1724 Ф Гудамж, Н. В.,
Вашингтон, Д. С. 20508
Утас: (202) 395-6186

Уулзахыг хүсэгсэд дээр бичсэн утас руу залгаж урьдчилан цаг авах ёстой. Уулзах боломжтой цаг нь Даваагаас Баасан гаригийн хооронд өглөөний 9.30-аас үд дунд хүртэл буюу үдээс хойш 1-ээс 4 цаг хүртэл байж болно.

ХЕС-ИЙН ТАЛААР ИХЭВЧЛЭН ТАВЬДАГ АСУУЛТУУД

1. ХЕС-д хамаарах бараа бүтээгдэхүүн
2. ХЕС-д хамаарах хөгжиж буй ашиг хүртэгч улс орнууд
3. Өрсөлдөөнт хэрэгцээний хязгаарлалт ба түүнээс чөлөөлөгдөх тухай хүсэлт
4. ХЕС-өөс ашиг хүртэгч улс орон түүнд хамаарахгүй болох буюу статус өөрчлөгдөх
5. Гарал үүслийн талаар тавигдах шаардлага
6. “Шууд импортлох”-од тавигдах шаардлагууд
7. Гар аргаар үйлдвэрлэсэн бөс даавуун бүтээгдэхүүн
8. Бусад асуудлууд

1. ХЕС-д хамаарах бараа бүтээгдэхүүн

АНУ руу импортоор оруулах ямар нэр төрлийн бараа бүтээгдэхүүн ХЕС-ийн дагуу гаалийн татвараас чөлөөлөгдөх вэ?

ХЕС-д хамаарах импортын бараа бүтээгдэхүүн нь дараахь шаардлагыг хангасан байх ёстой (доор илүү дэлгэрэнгүй тайлбарласан):

- (1) ХЕС-д хамаарах бараа бүтээгдэхүүний жагсаалтад орсон байх ёстой.
- (2) Уг бараа бүтэгдэхүүн нь нэр дурдсан ашиг хүртэгч хөгжиж буй орон (АХХБО) буюу холбооноос шууд импортлогдож байх ёстой.
- (3) АХХБО буюу холбоо нь тухайн төрлийн бара бүтээгдэхүүнийхээ хувьд ХЕС-д хамрагдсан байх ёстой.
- (4) Уг бараа бүтэгдэхүүн нь АХХБО-д ургуулсан буюу үйлдвэрлэсэн бараа байх бөгөөд нэмэгдсэн өртгийн шаардлагыг биелүүлж байх ёстой.
- (5) Бараа экспортолж буй буюу импортолж буй этгээд нь Барааны уялдуулсан систем (БУС)-ийн дугаарын өмнө “A” тэмдэг тавьж ХЕС-ийн дагуух гаалийн татвараас чөлөөлөгдөх хүсэлтээ гаргах ёстой бөгөөд БУС-н дугаар нь тээвэрлэлтийн холбогдох баримт бичиг (7501 тоот маягт)-т импортолж буй бараа бүтээгдэхүүнийг тодорхойлох юм.

Ямар бараа бүтээгдэхүүн гаалийн татваргүйгээр хилээр нэвтрэх эрхтэй байх вэ?

ХЕС-ийн ашиг хүртэгч нараас импортлох ойролцоогоор 3400 нэр төрлийн бараа бүтээгдэхүүн гаалийн татваргүй барааны ангилалд багтана. 1996 онд зөвхөн нэн буурай хөгжилтэй хөгжиж буй ашиг хүртэгч орнууд (НБХХБАХО)-аас импортлох 1400 нэр төрлийн бараа бүтээгдэхүүнийг гаалийн татваргүй барааны ангилалд нэмж тусгасан. Нэгтгэсэн жагсаалтад гаалийн татвар ногдуулах ихэнх нэр төрлийн бүрэн ба хагас боловсруулсан бараанаас гадна бусад тохиолдолд гаалийн татвараас чөлөөлөгдөхөөргүй хөдөө аж ахуй, загас агуурын болон аж үйлдвэрийн анхдагч зарим тусгайлан сонгосон бүтээгдэхүүнүүд багтаж буй. НБХХБАХО-уудыг 1974 оны Худалдааны хуулийн нэмэлт, өөрчлөлт хийсэн 502(а)(2) дахь заалтад тодорхойлж бичсэн бөгөөд тэдгээр орнууд нь

практик дээр голчлон Нэгдсэн Үндэстний Байгууллагын нэн буурай хөгжилтэй орнуудын жагсаалтад орсон ашиг хүртэгч улсууд байна. Зарим АХХБО-үүд болон НБХХБАХО-үүдиг хөдөлмөрчдийн эрх, оюуны өмчийн болон хуулиар тогтоогдсон бусад асуудлаар гаргасан хүсэлтийг хүлээн авсны улмаас ХЕС-д хамаарах улсуудын жагсаалтаас хассан.

ХЕС-д хамаарах бараа бүтээгдэхүүний нэр төрлийг АНУ-ын Олон улсын худалдааны комиссоос хэвлэн гаргадаг Барааны уялдуулсан систем (БУС)-ийн одоогоор мөргөгдөж буй хувилбарт тодорхойлж бичсэн буй. Барааны уялдуулсан систем (БУС)-ийн бүрэн гүйцэд баримт бичгийг АНУОУХК-ийн вэб сайт (<http://www.usitc.gov/tata/hts/>)-аас татаж үзэх буюу АНУ-ын Худалдааны төлөөлөгчийн газрын Уншлагын танхим, Худалдааны департаментын салбар төлөөлөгчийн газрууд болон өөрийн орон дахь АНУ-ын Элчин сайдын яам буюу Консулын албанад очиж уншиж танилцах боломжтой. АНУОУХК АНУ-ын давуу эрх олгох хөтөлбөрүүдэд хамаарах бараа бүтээгдэхүүний талаарх мэдээллийн санг бүрдүүлж хөтөлдөг бөгөөд уг сангаас мэдээллийг олохдоо Зохицуулалттай тарифийн хуваарийн зэрэглэлийн дугаараар хайж болох юм (http://dataweb.usitc.gov/scripts/gsp/gsp_tariff.asp).

Дурын нэг бараа бүтээгдэхүүнийг ХЕС-д хамааруулж болох уу?

Болохгүй. Тодорхой нэр төрлийн зарим бараа бүтээгдэхүүнийг хуулиар (19 U.S.C. 2463) ХЕС-д хамааруулахгүй байхаар тогтоосон байдаг. Эдгээр бараа бүтээгдэхүүн нь 1995 оны 1-р сарын 1-ний өдрийн байдлаар ХЕС-д хамаараагүй нэр төрлүүд байх ба үүнд ихэнх нэр төрлийн бөс даавуу, цаг, гутал, гар цүнх, аяны цүнх, ажлын бээлий болон арьсаар хийсэн бусад бүтээгдэхүүнүүд хамаарна. Үүнээс гадна импортын хувьд эмзэг гэж тодорхойлогдсон бусад бараа бүтээгдэхүүн ХЕС-д хамаардаггүй. Ийм төрлийн бүтээгдэхүүнд ХЕС-ийн хуулиар ган, шил ба электроникийн барааг тусгайлан хамааруулсан.

(http://www.ustr.gov/assets/Trade_Development/Preference_Programs/GSP/asset_upload_file15_1_8358.pdf)

Барааны Уялдуулсан Систем (БУС)--т ямарваа барааг ХЕС-д хамаарах бүтээгдэхүүн гэж хэрхэн тодорхойлсон бэ?

Барааны уялдуулсан систем (БУС) дахь “Тусгай” тарифийн гэсэн баганад буй “A” тэмдэглэгээгээр тухайн бараа ХЕС-д хамаарч байгааг таньж болно. ХЕС-д хамаарах өөр өөр нэр төрлийн бүтээгдэхүүн хэрхэн ялгагдах байдлаар ангилагдаж болохыг дараах хүснэгт дэх БУС-ийн тарифийн гурван мөрөөс харж болох юм. БУС-т буй ХЕС-д хамаарах бараа бүтээгдэхүүний нэр төрлийн ард байх “Тусгай” тарифийн гэсэн баганад A, A+, эсвэл A* гэсэн тэмдэглэгээгээр тухайн бүтээгдэхүүнийг тодорхой нөхцлийн үндсэн дээр ХЕС-д хамааруулдаг. “A” үсгээр бүх АХХБО-үүдийн хувьд ХЕС-д хамаарах бүтээгдэхүүнийг тэмдэглэсэн. A+ тэмдгээр зөвхөн НБХХБО-уудаас импортлох бүтээгдүүнийг ялгана. A* үсэг нь тухайн тэр төрлийн бүтээгдэхүүний хувьд ХЕС-д хамарагдахгүй болсон нэг буюу хэд хэдэн АХХБО-уудаас импортлох бараанаас бусад, ХЕС-д хамаарах бүтээгдэхүүнийг тэмдэглэсэн. БУС-т бүтээгдэхүүний ХЕС-д хамаарах байдлыг дараахъ загвараар

тодорхойлно. Үүнд:

БУС-ийн дэд бүлэг	Бүтээгдэхүүний нэр төрөл	Гаалийн татварын хувь хэмжээ (%)		
		Багана 1		Багана 2
		Ердийн	Тусгай	
8406.10.10	Усан онгоцны уураар ажилладаг хөдөлгүүр	6.7	Чөлөөт А	20
8413.30.10	Компрессын шаталтат хөдөлгүүрийн түлш шахах насос	2.5	Чөлөөт А*	35
8708.92.50	Дуу намсгагч болон утааны яндан	2.5	Чөлөөт А+	25

БУС-ийн Ерөнхий тайлбарын 4(d) хэсэгт А* тэмдэг бүхий бараа бүтээгдэхүүний тухайд хязгаарлалт тогтоосон АХХБО-уудыг тодорхойлсон. “ХЕС-д хамаарах улсууд” гэсэн дорх тайлбарыг үзнэ үү.

ХЕС-д хамаарах бараа бүтээгдэхүүнд ногдуулах гаалийн татварын хувь хэмжээ ямар байх вэ?

ХЕС-д хамаарах бүх бараа бүтээгдэхүүний импортыг гаалийн татвараас чөлөөлнө.

Toхирох ангилиг хэрхэн тодорхойлох вэ?

АНУ-ын Гаалийн ба Хилийн Хамгаалалтын товчоо (урьд нь АНУ-ын Гаалийн алба хэмээн нэрийддэг байсан) БУС-ийн дагуу импортын бараа бүтээгдэхүүнийг нэг бүрийн тодорхойлолтын хамт ангилах үүрэгтэй юм. Тодорхой нэр төрлийн бараа бүтээгдэхүүний тохирох ангилийн талаарх дурын асуултыг хилийн боомтын гаалийн ажилтнууд буюу Вашингтон Д. С. дэх зохицуулалт ба дүрэм журамтай холбоотой асуудал хариуцсан Гаалийн албанд тавьж болно. Гаалийн алба ХЕС-ийн хөтөлбөрийн үндсэн шаардлагын талаар болон ХЕС-д хамрагдах хүсэлтийг хүлээн авахуулах үүднээс хууль дүрмийн шаардлагад нийцэхүйц дотоодын хяналт шалгалтын тогтолцоог хэрхэн бий болгож эхлэх тухай импортлогчдод мэдээлэх үүргийнхээ дагуу бүрдүүлэх бичиг баримтыг өгнө. Тэдгээр нь http://www.cbp.gov/xp/cgov/import/reg_audit/archive/gsp.xml хаягт буй. Гаалийн дүрэм, журмыг хэвлэж тараадаг бөгөөд цахим хэлбэрээр <http://rulings.cbp.gov> гэсэн вэб сайтаас үзэх боломжтой.

2. ХЕС-д хамаарах Хөгжисж буй ашиг хүртэгч орнууд

Тусгаар улсууд, нутаг дэвсгэр, улсуудын холбоод болон НБХХБО-уудыг

оролцуулан ХЕС-д хамаарах бүх улс орнуудын жагсаалт ба орнуудыг хамаарлаар үзүүлсэн бараа бүтээгдэхүүний жагсаалтыг хаанаас үзэж болох вэ?

БУС-ийн эхэнд буй Ерөнхий тайлбарын 4(a)-р хэсэгт ХЕС-д хамаарах этгээдүүдийн албан ёсны жагсаалт байгаа. 4(c)-р хэсгээс НБХХБО-уудын жагсаалтыг харж болно. 4(d)-р хэсэгт ХЕС-д хамаарах зарим орнуудын тус нөхцөлд хамаарахгүй импортын бараа бүтээгдэхүүний жагсаалтыг оруулсан. АХХБО-ыг анх тодорхойлж, ХЕС-д хамаарах байдал нь өөрчлөгдсөн бол Холбооны бүртгэлийн албанд мэдэгдэл очдог. Ерөнхий тайлбарт буй жагсаалтуудыг тэдгээр өөрчлөлтүүдийг тусгаж шинэчилж байдаг. Доорх мэдээллийг үзнэ үү.

ХЕС-ийн дагуу бараа бүтээгдэхүүн нийлүүлэх хүсэлтээ импортлогч хэрхэн гаргах вэ?

Тээвэрлэлтийн баримт бичиг дэх БУС-ийн тарифийн мөрний дугаарын өмнө А үсэг тавьж хүсэлтээ гаргана. Энэ үсэг нь Тусгай Хөтөлбөрийн тодорхойлогч (TXT) тэмдэг болно.

ХЕС-д хамаарах жагсаалтаас зарим нэр төрлийн бараа бүтээгдэхүүнийг хэрхэн хасуулах вэ?

Ерөнхийлөгч дараах гурван үндэслэлээр бараа бүтээгдэхүүнийг жагсаалтаас хасна. Үүнд:

- (1) жилийн үзлэг шалгалтын үеэр сонирхогч этгээдүүд энэ тухай хүсэлт гаргасан бол түүнийг биелүүлэхийн тулд;
- (2) тухайн нэр төрлийн бараа бүтээгдэхүүний тухайд зарим АХХБО-ыг ХЕС-д хамаарах орны уагсаалтаас хасч, оронд нь шинэ бараа бүтээгдэхүүнийг оруулах; болон
- (3) тодорхой АХХБО-уудад зарим барааг хамааруулахаас татгалзах замаар тогтоосон нэр төрлийн барааг ХЕС-д дахин хамааруулах.

ХЕС-д хамаарах бараа бүтээгдэхүүн болон орнуудын жагсаалтад өөрчлөлт орж байсан уу?

Тийм ээ. ХЕС-ийн асуудлыг хариуцсан дэд хороогоор дамжуулан АНУ-ын Засгийн газар гаалийн татвараас чөлөөлөгддөг бараа бүтээгдэхүүн буюу улс орнуудын жагсаалтад жил бүр шалгалт хийдэг. Жагсаалтад оруулсан нэмэлт, өөрчлөлтийг шалгалт хийсний дараагийн хуанлийн жилийн 7-р сарын 1-нээс мөрдөж эхэлдэг.

Бараа бүтээгдэхүүн буюу улс орнуудын жагсаалтад хэрхэн өөрчлөлт оруулж болох вэ?

Хүссэн хэн ч бай ХЕС-д хамаарах орнуудын жагсаалтад нэмэлт, өөрчлөлт оруулах хүсэлтээ ХЕС-ийн асуудлыг хариуцсан дэд хороонд тавьж болно. Харин ХЕС-д хамаарах

бараа бүтээгдэхүүний жагсаалтад нэмэлт, өөрчлөлт оруулах хүсэлтийг зөвхөн “сонирхогч талууд” л тавьж шийдвэрлүүлэх эрхтэй. Эрх зүйн баримт бичгийн энэхүү заалтад тодорхойлсноор сонирхогч тал гэдэг нь тавьж буй хүсэлтийнхээ агуулгад эдийн засгийн маш чухал ач холбогдол өгч байгаа аливаа тал, эсвэл төсөөтэй буюу шууд өрсөлдөхүйц бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг дотоодын үйлдвэрлэгч, ХЕС-д хамаарах буюу түүнд хамааруулах хүсэлт гаргасан бүтээгдэхүүний импортлогч, эсвэл жижиглэн худалдагч, эсвэл гадаад улсын засгийн газар зэрэг тавьж шийдвэрлүүлэх гэж буй асуудал нь өөрийнх нь эдийн засгийн маш чухал ашиг сонирхолд материалыг байдлаар нөлөөлөх аливаа бусад тал юм. Аль нэг жилийн шалгалтын явцад шийдвэрлүүлэхийн тулд хүсэлтийг Холбооны бүртгэлийн албанаас жил бүр зарладаг тухайн жилийн шалгалтын явцад хүсэлтээ гаргаж болох эцсийн хугацаанд багтааж ХЕС-ийн асуудлыг хариуцсан дэд хороонд гаргаж өгөх ёстай. (ХЕС-д хамрагдах хүсэлтийн талаарх мэдээллийг дороос үзнэ үү). Хүсэлт нь хүчин төгөлдөр үйлчилж буй дурэм, журамд нийцсэн байх ёстай. Хянан шийдвэрлэхээр хүлээн авсан хүсэлтийг нийтэд мэдээлэх бөгөөд түүнийг АНУ-ын худалдааны бодлоготой холбоотой үйл ажиллагаа явуулдаг гол гүйцэтгэх департаменттүүд бүрэн хянах ёстай байдаг. Жилийн үзлэг шалгалтын дагуу хийгдсэн нэмэлт, өөрчлөлтүүдийг тушаал буюу Ерөнхийлөгчийн зарлиг гарснаар мөрдөж эхлэх бөгөөд Холбооны бүртгэлд хэвлэн нийтэлдэг.

ХЕС-д хамаарах бараа бүтээгдэхүүн болон орнуудын жагсаалтад нэмэлт, өөрчлөлт оруулахад ямар хүчин зүйлсийг харгалzan үздэг вэ?

ХЕС-д хамаарах бараа бүтээгдэхүүн болон улс орнуудын жагсаалтад нэмэлт, өөрчлөлт оруулахдаа дараах хүчин зүйлсийг харгалзан үзэх ёстай. Үүнд:

- (1) тухайн улсын экспортын эдийн засгийн цаашдын өргөжилт хөгжилтөд уг арга хэмжээний үзүүлэх нөлөө;
- (2) бусад гол хөгжингүй орнуудын зүгээс хөгжиж буй орнуудын үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүний импортоод ХЕС олгох замаар тэдэнд туслалцаа үзүүлэхээр мэрийж буй хүчин чармайлтын хэр хэмжээ;
- (3) тухайн бараатай төсөөтэй буюу шууд өрсөлдөхүйц бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг АНУ-ын үйлдвэрлэгчдэд уг арга хэмжээний үзүүлж болох нөлөө; болон
- (4) ХЕС-д хамаарах бараа бүтээгдэхүүний хувьд тухайн орны өрсөлдөх чадвар хэрхэн нэмэгдэх зэрэг багтана.

Үүний хажуугаар аливаа улсыг ХЕС-д хамруулахын тулд Ерөнхийлөгчийн зүгээс заавал буюу сайн дурын үүднээс харгалзан үзэх ёстай хүчин зүйлсийг дүрэмд заасан байдаг. (19 USC-ийн 2462(b) ба (c) заалтууд). Эцэст нь дүрэмд ХЕС-д хамрагдахгүй бараа бүтээгдэхүүний жагсаалтыг тусгасан. (19 USC-ийн 2463(b) заалт).

АНУ-ын ХЕС-ийн хөтөлбөр 1976 оноос хэрэгжиж эхэлсэн гэдэг утгаараа ХЕС-д одоогоор хамрагдахгүй байгаа олон нэр төрлийн бараа бүтээгдэхүүнүүдийг түүнд хамруулах

эсэхийг өмнөх жилүүдэд хянаж үзсэн байдал. Тухайн нэр төрлийн бүтээгдэхүүний талаар гаргаж байсан хүсэлтийн түүхийг үзвэл түүнийг ХЕС-д хамруулах боломжийн талаар хэрэгтэй мэдээллийг олж болох юм. Гаргаж байсан хүсэлтүүдийн олон нийтэд зориулан бэлдсэн хувилбарыг АНУ-ын Худалдааны төлөөлөгчийн газрын Уншлагын танхимд буй баримтуудаас үзэж болно. Уулзалтын товыг тогтоохын тулд 202-395-6186 дугаарын утас руу залгана уу.

ХЕС-д хамаарах бараа бүтээгдэхүүн болон ул орнуудыг хаанаас тодорхойлдог вэ?

ХЕС-тэй холбоотой асуудлуудыг АНУХТГ-аас удирдан зохион байгуулдаг агентлаг хоорондын худалдааны бодлогын хорооны хүрээнд хянан шийдвэрлэдэг. Худалдааны бодлоготой холбоотой үйл ажиллагаа явуулдаг салбар хариуцсан гол гүйцэтгэх департаментүүд ХЕС-д хамрагдах шаардлагад оруулах нэмэлт, өөрчлөлтөд агентлаг хоорондын хяналт шалгалт хийх ажиллагаанд оролцдог. Энэхүү ажиллагаанд оролцох агентлаг бүр АНУХТГ-ын удирдлагад ажилладаг ХЕС-тэй холбоотой асуудал хариуцсан дэд хороонд өөрийн төлөөлөлтэй байна. АНУХТГ нь Гүйцэтгэх захирлын зааварчилга дор ХЕС-тэй холбоотой өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулдаг. ХЕС-д ямар улс орон буюу ямар нэр төрлийн бараа бүтээгдэхүүнийг хамруулахыг Ерөнхийлөгч эцэслэн шийдвэрлэнэ.

Ашиг хүртэгч улс бүх нэр төрлийн бараа бүтээгдэхүүний хувьд гаалийн татвараас чөлөөлөгддөг үү?

Үгүй. Аль нэг АХХБО-ы тодорхой нэр төрлийн барааны импорт буюу нийлүүлэлт дараахь шалтгааны улмаас ХЕС-д хамрагдахгүй байж болно. Үүнд: (1) тэдгээр нь хэрэгцээний хязгаараас давсан тохиолдолд (дор үзнэ үү); (2) жилийн үзлэг шалгалтын явцад гаргасан хүсэлтийн үндсэн дээр тухайн бүтээгдэхүүний ХЕС-д хамрагдах боломжийг хаасан; (3) тухайн импорт нь нэмэгдсэн өргийн шаардлагыг хангаагүй бол; (4) импортлогч баримт бичгийг бүрэн бүрдүүлж өгөөгүй бол; эсвэл (5) тухайн импорт нь Гаалийн албаны бусад шаардлагыг хангаагүй бол.

3. Өрсөлдөөнт хэрэгцээний хязгаарлалт ба түүнээс чөлөөлөгдөх тухай хүсэлт

Өрөөлдоөнт хэрэгцээний хязгаар гэж иу вэ?

Хэрэгцээний хязгаар нь тухайн нэр төрлийн бүтээгдэхүүн буюу АХХБО болгоны ХЕС-өөс ашиг тус хүртэх боломжид тавьж буй хязгаарлалт юм. Тухайн нэр төрлийн бүтээгдэхүүний тоо хэмжээ хэрэгцээний хязгаараас давсан бол аль нэг АХХБО ХЕС-д хамрагдах боломжкоо шууд алдана (түүнээс чөлөөлөгдөх хүсэлтийг хүлээж аваагүй бол – дор үзнэ үү). Уг хуанлийн жилийн туршид тухайн улсаас АНУ руу оруулах импорт дараахь хувь хэмжээнд хүрсэн буюу дорх хязгаарыг давсан нөхцөлд хэрэгцээний хязгаарын дагуу тухайн АХХБО-ны уг нэр төрлийн бараа бүтээгдэхүүний ХЕС-д

хамрагдах боломжийг хаадаг. Үүнд: (1) тухайн нэр төрлийн бүтээгдэхүүний АНУ руу нийлүүлсэн импортын хэмжээ нь тус улсын уг бүтээгдэхүүний нийт импортын үнэлгээний 50%-тай тэнцэх буюу түүнээс хэмжээнд хүрсэн бол; эсвэл (2) тухайн нэр төрлийн бүтээгдэхүүний үнэ америк доллараар тогтоосон тодорхой үнийн хязгаарыг жил бүр 5 сая долларын нэмэгдүүлэх ёстой. 2006 онд уг хязгаар 125 сая доллар байсан бол 2007 онд түүнийг 130 сая долларын хүргэж нэмэгдүүлсэн бөгөөд 2008 онд 135 сая доллар болох ёстой. Аль нэг ашиг хүргэгчээс импортолсон бүтээгдэхүүний хэмжээ буюу үнэ дээр дурдсан хязгааруудын нэгийг давсан тохиолдолд уг бүтээгдэхүүнийг “хангалттай өрсөлдөхүйц” гэсэн ангилалд хамааруулаха юм. Дурэмд зааснаар дээр дурдсан хэрэгцээний хязгааруудын аль нэгийг давсан тохиолдолд уг бүтээгдэхүүнийг дараагийн хуанлийн жилийн 7-р сарын 1-ний өдрөөс эхлэн ХЕС-д хамруулахгүй болгоно.

Өрсөлдоонт хэрэгцээний хязгаараас чөлөөлөгдсөн тохиолдол байдал уу?

Тийм ээ. Дор дурдсан дөрвөн нөхцөл байдал үүсэн тохиолдолд хэрэгцээний хязгаараас чөлөөлдөг.

Өрсөлдоонт хэрэгцээний хязгаараас чөлөөлөх арга хэмжээний төрлүүд

Хүсэлт гаргаж чөлөөлөгдсөн	Хувь хэмжээгээр тогтоосон хязгаараас чөлөөлсөн	Тогтоосон үнийн хязгаарлалтаас чөлөөлсөн
“504(d)” заалтын дагуу чөлөөлөгдсөн	Тийм	Үгүй
Де Минимис нөхцлөөр чөлөөлөгдсөн	Тийм	Үгүй
Нэн буурай хөгжилтэйн учир чөлөөлөгдсөн	Тийм	Үгүй

Хүсэлт гаргаж чөлөөлөгдөх: ХЕС-ийн тухай хуульд 1984 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн үр дүнд АХХБО-оос нийлүүлж буй импортын бүтээгдэхүүнийг Ерөнхийлөгчийн шийдвэрээр өрсөлдөөнт хэрэгцээний хязгаарлалтаас чөлөөлж болдог болсон. Тухайн нэр төрлийн бүтээгдэхүүний нийлүүлэлт зөвхөн хэрэгцээний хязгаараас даваагүй нөхцөлд л сонирхогч талууд түүнээс чөлөөлөгдөх хүсэлтээ гаргаж болно. Ерөнхийлөгч хязгаараас чөлөөлөх тухай шийдвэр гаргахдаа тухайн орон АНУ-ын бараа, үйлчилгээнд өөрийн зах зээлээ хэр зэрэг бодитой бөгөөд хувь тэнцүүлсэн байдлаар нээж өгч байгаад болон АНУ-ын оюуны өмчийн эрхийг хэр бодитой бөгөөд үр дүнтэйгээр хамгаалж буйд “өндөр ач холбогдол” өгөх ёстой. Хязгаараас чөлөөлөх шийдвэр гарсан бол импортын бүтээгдэхүүний хэмжээ болон үнийн хязгаараас давхар чөлөөлдөг. Хязгаараас чөлөөлөх шийдвэр нь нөхцөл байдал өөрчлөгдсөний улмаас Ерөнхийлөгчийг шийдвэрээ

бүрчлөх хүртэл хүчинтэй байна. Дүрэмд зааснаар бол аль нэг улсаас өмнөх хуанлийн жилд импортолсон ХЕС-д хамрагдах тодорхой нэр төрлийн бүтээгдэхүүний үнэлгээ тухайн жилийн америк доллараар илэрхийлсэн үнэлгээний хязгаараас 150-иас дээш хувиар хэтэрсэн, эсвэл АНУ-ын нийт импортын хэмжээний 75%-иас давсан тохиолдолд 5-аас цөөнгүй жил хүчинтэй байсан чөлөөлөх шийдвэрийг Ерөнхийлөгч цуцлах ёстай.

Өрсөлдөөнт хэрэгцээний хязгаарлалтаас чөлөөлөх эрх мэдэлд тавигдах хязгаарлалт: Хэрэгцээний хязгаарлалтаас чөлөөлөгдсөний ашиг тусыг хүртэгч бүх улсаас АНУ-ын импортоор авсан бүтээгдэхүүний нийт үнэлгээ тухайн хуанлийн жилд хийгдсэн ХЕС-д хамрагдах бүтээгдэхүүний нийт импортын хэмжээний 30%-иас хэтэрч болохгүй. Нэг хүнд ногдох үндэсний нийт бүтээгдэхүүний хэмжээ нь 5000 америк доллараас давж буй орнууд буюу ХЕС-өөр олгож буй нийт үр өгөөжийн 10% буюу түүнээс дээш хувийг хүртэж буй улсуудыг ХЕС-ийн дагуух нийт импортын 15%-иас хэтэрсэн хэмжээний өрсөлдөөнт хэрэгцээний хязгаарлалтаас чөлөөлж болохгүй юм.

“504(d)” заалтын дагуу чөлөөлөх: Тухайн үеийн ХЕС-ийн тухай дүрмийн “504(d)” заалт буюу одоогийн 19 USC-ийн 2463(c)(2)(E) заалтын дагуу 1995 оны 1-р сарын 1-ний байдлаар АНУ-д үйлдвэрлэгдээгүй байсан ХЕС-д хамрагдах тодорхой нэр төрлийн бүтээгдэхүүнийг хувь хэмжээний хязгаарлалтаас чөлөөлсөн.

(http://www.usit.gov/assets/Trade_Development/Prefecture_Programs/GSP/asset_upload_file15_1_8358.pdf) Жилийн үзлэг шалгалтын явцад сонирхогч талууд хязгаарлалтаас чөлөөлөгдөх хүсэлтээ гаргаж болно. Энэхүү жагсаалтад орсон бүтээгдэхүүнийг “504(d)” заалтын дагуу шаардлагатай бол жил бүр хязгаарлалтаас шууд чөлөөлөх боломжтой.

Де Минимис нөхцлөөр чөлөөлөгдөх: Бүх улс орнуудаас АНУ-ын авч буй тухайн нэр төрлийн бүтээгдэхүүний нийт импорт бага хэмжээтгэй буюу “де минимис” байгаа нөхцөлд хязгаарлалтаас чөлөөлөгдөж болно. Де минимис хэмжээг доллараар илэрхийлсэн өрсөлдөөнт хэрэгцээний хязгаарлалтай адилаар жил бүр 0,5 сая долларын шаталбараар тохируулан өөрчилдөг. Ийм учраас де минимис хэмжээ нь 2006 онд 18 сая доллар байсан бол 2007 онд 18,5 сая доллар болж, 2008 онд 19 сая долларт хүрч нэмэгдэх учиртай. Өмнөх жилд бүх улсуудаас хийсэн тухайн нэр төрлийн бүтээгдэхүүний нийт импортын хэмжээ де минимис түвшинд байсан бол уг бүтээгдэхүүний өрсөлдөөнт хэрэгцээний хязгаарлалтаас хэтэрсэн бүх АХХБО-уудын тухайд де минимис нөхцлөөр чөлөөлөх нөхцөл олгохыг тухайн чөлөөлөх нөхцлийн дагуу жил бүр хянаж үздэг. Энэхүү төрлийн чөлөөлөх нөхцлийг эдлэх хүсэлтийг гаргах боломжгүй боловч Холбооны бүртгэлийн эмхэтгэл хэвлэгдэн гарсны дараа олон нийтийн санаа бодлын дагуу шийдвэрлэх боломжтой. Ийм төрлийн чөлөөлөх нөхцөл олгох эсэхийг Ерөнхийлөгч өөрийн үзэмжээр шийдвэрлэнэ.

Нэн буурай хөгжилтэйн учир чөлөөлөгдөх: ХЕС-өөс ашиг хүртэгч НБХХБО-оор тогтоогдсон улсуудыг хэрэгцээний бүх төрлийн хязгаарлалтаас шууд чөлөөлнө.

Тухайн жилийн хувьд импортын хэмжээ нь өрсөлдөөнт хэрэгцээний хязгаарлалтад хүрэх буюу түүнээс хэтэрсэн бол яах вэ?

Ийм нэхцэл байдалд орсон орнуудаас импортлох бүтээгдэхүүний ХЕС-д хамрагдах боломж нь дараагийн хуанлийн жилийн 7-р сарын 1-ний өдөр хүртэл хэвээр хадгалагдах боловч өрсөлдөөнт хэрэгцээний хязгаарлалтаас хэтэрсэн жилийн ХЕС-ийн үзлэг шалгалтаар хязгаарлалтаас чөлөөлөгдсөн бүтээгдэхүүн буюу ашиг хүртэгч этгээдэд энэ нь хамаарахгүй юм.

Өрсөлдөөнт хэрэгцээний хязгаарлалтаас чөлөөлөгдөх хүсэлтээ сонирхогч тал хэзээ гаргах хэрэгтэй вэ?

Тухайн орны бүтээгдэхүүний хэмжээ буюу үнэлгээ өрсөлдөөнт хэрэгцээний хязгаарлалтаас хэтрэхээс өмнө л хүсэлтээ гаргаж болох юм. Тухайн нэр төрлийн бүтээгдэхүүн хязгаарлалтыг давж болох эсэхийг тодорхойлохын тулд сонирхогч талууд худалдааны тоо баримтыг шүүж үзэх хэрэгтэй бөгөөд тухайн жилийн ХЕС-ийн үзлэг шалгалтаар тогтоосон эцсийн хугацаанаас өмнө хүсэлтээ гаргах ёстой. Дээр хэлсэнчлэн хэрэв хэрэгцээний хязгаар хэтэрсэн бөгөөд хязгаарлалтаас чөлөөлөх шийдвэр гараагүй бол уг ашиг хүртэгч орны тухайн бүтээгдэхүүний ХЕС-д хамрагдах боломж нь дараа жилийн 7-р сарын 1-ний өдрөөр дуусгавар болно.

Алива бүтээгдэхүүний импортыг сонирхогч тал хянах боломжтой юу?

Болно. Худалдааны департаментын Худалдааны талаар мэдээлэл авах танхим ((202) 482-2185 дугаарын утсаар) буюу Тооллогын товчооны Худалдааны мэдээллийн алба ((301) 457-3041 дугаарын утсаар) нийт импортын бүтээгдэхүүний нийлүүлэлтийн талаарх мэдээллийг сар бүр нэгтгэж байдаг. Статистикийн мэдээг авахын тулд БАРААНЫ УЯЛДУУЛСАН СИСТЕМ (БУС)-ийн 8 оронтой тоогоор илэрхийлэгдсэн тарифийн дугаараар хайж олно. Худалдааны жилийн болон сар тутмын мэдээллийг мөн АНУ-ын Олон улсын худалдааны комиссийн мэдээллийн вэб хуудас болох (<http://dataweb.usitc.gov/>)-оос авар боломжтой. Вэб сайтад нэвтрэхийн тулд бүртгүүлэх шаардлагатай боловч элсэлтийн хураамж авахгүй.

Тухайн нэр төрлийн бүтээгдэхүүн өрсөлдөөнт хэрэгцээний хязгаарлалтыг давсан учраас ХЕС-д хамрагдах жагсаалтаас хасагдсан тохиолдолд тодорхой нэг улсаас нийлүүлсэн уг бүтээгдэхүүнийг дээрх жагсаалтад дахин оруулж болох уу?

Болно. АНУ руу яригдаж буй улсаас импортолсон тухайн нэр төрлийн бүтээгдэхүүний хэмжээ дараагийн жилд өрсөлдөөнт хэрэгцээний хязгаарлалтын түвшнээс доогуур байвал уг АХХБО өөрийн бүтээгдэхүүнийг ХЕС-д хамрагдах барааны жагсаалтад дахин оруулахыг хүссэн өргөдлөө өгөх боломжтой. Үүнийг шийдвэрлэхдээ ихэвчлэн улс орнуудын статусын өөрчлөлтийн дор дурдсан хүчин зүйлсээс хамааруулан авч үздэг.

4. ХЕС-д хамрагдах жагсаалтаас Ашиг хүртэгч улсыг хасах

Статусын өөрчлөлт гэдгийг юу гэж ойлгох, мөн үүнийг хэрхэн хийдэг вэ?

Статусын өөрчлөлт гэдэг нь тухайн улс хангалитай түвшинд хүртлээ хөгжсөн, эсвэл бүх бүтээгдэхүүний хувьд буюу нэг ба хэд хэдэн нэр төрлийн бүтээгдэхүүний хувьд ХЕС-д хамрагдах шаардлагагүй болтлоо өрсөлдөх чадвар нь и nemэгдсэн тохиолдолд ХЕС-д хамрагдах улс орнуудын жагсаалтаас түүнийг хасахыг хэлнэ. Аль нэг АХХБО-ны зүгээс гаргасан гаалийн татвараас чөлөөлөгдөх хүсэлтийг хүлээн авахаас татгалзах буюу түүнийг хянан хэлэлцэх асуудлыг хойшлуулах буюу хязгаарлах эрхтэй.

Аль нэг орны статус дараахь тохиолдолд өөрчлөгдөнө:

1. Ашиг хүртэгч орон “өндөр орлоготой улс” болсон гэдгийг Ерөнхийлөгч ХЕС-ийн тухай дурэмд (Дэлхийн банкны статистик мэдээ баримтад үндэслэн) заасны дагуу тогтоосон (“статусыг албадан өөрчлөх”); эсвэл
2. тухайн АХХБО-ны эдийн засгийн хөгжил болон худалдааны өрсөлдөх чадварт гарч буй ахиц дэвшилд дүн шинжилгээ хийсний дүнд.

Нэг хүнд ногдох ҮНБ-ий хязгаарыг Дэлхийн банкинд хэрэглэгддэг “өндөр орлоготой орнууд” (энэ нь 2005 онд 10,726 доллар байсан)-ын хамгийн доод шатлалаар тогтоодог [Эх сурвалж: Дэлхийн Банк]. Статусыг албадан өөрчлөх тухай шийдвэр Ерөнхийлөгчийг тухайн орны статусыг өөрчлөх шаардлагатайг тогтоосны удаахь жилийн 1-р сарын 1-гээс хэрэгжиж эхэлнэ.

Статусыг өөрчлөхийн тулд ямар хүчин зүйлсийг харгалzan үздэг вэ?

ХЕС-ийн тухай асуудлыг хариуцсан дэд хороо дараахь хүчин зүйлсийг авз үзнэ. Үүнд: (1) тухайн орны хөгжлийн ерөнхий түвшин; (2) тодорхой нэг нэр төрлийн бүтээгдэхүүний хувьд өрсөлдөх чадвар; (3) худалдаа, хөрөнгө оруулалт ба хөдөлмөрчдийн эрх ашигийг хамгаалахтай холбоотой тухайн орны практик; (4) нэгэнт олгогдсон ХЕС-ийг хэвээр Үргэлжлүүлснээр АНУ-ын холбогдох үйлдвэрлэгчид, ажилчид болон хэрэглэгчдэд үзүүлэх нөлөө гэх зэрэг АНУ-ын эдийн засгийн нийтлэг ашиг сонирхолд нөлөөлөх байдлын хэр хэмжээ; болон (5) холбогдох бусад мэдээллийн тулд.

5. Гарал үүслийн шаардлагууд

Гарал үүслийн шаардлагууд гэж юу вэ?

Аливаа импортын бүтээгдэхүүн ХЕС-д хамрагдахын тулд энэ нь АХХБО-ны өссөн бүтээгдэхүүн, бараа буюу үйлдвэрийн бараа материал байх ёстой бөгөөд тухайн АХХБО-нд үйлдвэрлэсэн бараа материалын өртөг зардлын нийт дүн, боловсруулалтын шууд зардлын нийлбэр нь тухайн бүтээгдэхүүний АНУ-ын нутаг дэвсгэрт орж ирэх үеийн үнэлгээний 35-аас доошгүй хувьтай тэнцүү байх шаардлага тавигддаг. Бараа бүтээгдэхүүн

ХЕС-ийн гарал үүслийн шаардлагад нийцэж буй эсэхийг мэдэж болох дүрэм журмыг <http://ulings.cbp.gov> гэсэн сайтаас үзэж болно.

Импортын бараа материалыг 35%-ийн нэмэгдсэн өртгийн шаардлагыг биелүүлсэнд тооцож болох уу?

Болно, гэхдээ тэдгээр бараа нь хожим нь ХЕС-д хамрагдах бараа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд ашиглагдах шинэ буюу өөр төрлийн бүрдэл материал болж “үлэмж хэмжээний хувиралт” хийгдсэн байх ёстой. ХЕС-д хамрагдах бус нутгийн холбоодын гишүүн улсуудыг тэдгээрээс импортолж буй бүтээгдэхүүний гарал үүслийг тогтоохын тулд нэг улсаар тооцдог. Гаалийн ба хилийн хамгаалалтын албаныхан тухайн бараа бүтээгдэхүүн ХЕС-ийн гарал үүслийн шаардлагыг хангаж буй эсэхийг тогтоох үүрэгтэй байна.

Хөгжисж буй орны экспортлогч импортын бүтээгдэхүүний үнэлгээг хэрхэн тогтоож болох вэ?

Олонх тохиолдолд барааны үнэлгээ нь тухайн гэрээ хэлцэлд заасан үнэ, өөрөөр хэлбэл тухайн бүтээгдэхүүнийг АНУ руу экспортлох үнэд төлөх буюу бодитоор төлсөн үнэд үндэслэгдэнэ. Энэхүү үнэлгээг түүний дараах бүрдэл хэсгүүд бий болгодог. Үүнд: (1) худалдан авагчийн төлсөн баглаа боодлын зардал; (2) худалдан авагчийн төлсөн худалдааны комисс; (3) ямар нэг хэлбэрийн туслалцааны үнэ хөлс; (4) худалдааны иөхцлийн дагуу худалдан авагчийн төлсөн эрхийн шимтгэл (роялти) буюу лицензийн хураамж; ба (5) дамжуулан худалдсаны буюу захиран зарцуулсны улмаас, эсвэл импортын барааг хэрэглэснээр худалдагчийн олж авах аливаа орлого. Ерөнхийдөө ХЕС-д хамрагдах бараа бүтээгдэхүүнийг экспортолж буй боомтоос АНУ руу тээвэрлэхтэй холбоотой тээврийн болон холбогдох бусад зардлуудыг тухайн бүтээгдэхүүний үнэлгээ ба нэмэгдсэн өртгийн тооцоонд аль алинд нь оруулдаггүй.

Боловсруулалтын шууд зардалд ямар зардлыг оруулж болох вэ?

Боловсруулалтын шууд зардалд тухайн импортын худалдааны зүйл болж буй өссөн бараа, үйлдвэрлэл болон үйлдвэрийн барааг бий болгоход буюу явуулахад зайлшгүй шаардлагдах, эсвэл тодорхой үндэслэлээр дээрх үйл ажиллагаанд хамааруулж болох бүх төрлийн зардлуудыг багтаадаг. Эдгээрт нэмэлт тэтгэлэг, тэтгэмж болон үйлдвэрлэлийн үйл явцад оролцож буй ажиллагсад ба анхан шатны шалгалт хийдэг зааварлагчдад ажлын байран дээр явуулах сургалтын зардал зэрэг хөдөлмөрийн зардлууд; хэв, цутгуур ба багаж хэрэгслийн зардал, түүнчлэн багаж хэрэгсэл ба тоног төхөөрөмжийн элэгдэл; судалгаа шинжилгээ, бүтээгдэхүүн, үйл явцын хөгжил, чанарын шалгалт, хяналт шалгалт болон сорил туршилтын зардлууд багтана. Энэ нь бүрэн гүйцэд жагсаалт биш болох учраас үнэлгээтэй холбоотой нэмэлт мэдээллийг Гаалийн албанаас алв болно.

Ямар төрлийн зардлыг боловсруулалтын шууд зардалд тооцож болохгүй вэ?

Боловсруулалтын шууд зардалд тооцож болохгүй зардлуудад тухайн тодорхой импортын худалдаанд шууд хамааруулах боломжгүй, эсвэл үйлдвэрлэлийн зардалд хамаарахгүй зардлуудыг багтаадаг. Эдгээр зардлуудад ашиг, срөнхий зардлуудаас гадна захиргааны цалин, ослын болон хариуцлагын даатгал, зар сурталчилгаа, худалдааны төлөөлөгчдийн цалин, комисс болон холбогдох бусад зардлууд гэх мэт бизнесийн нэмэгдэл зардлуудыг хамруулдаг.

6. “Шууд импортлох” үйл ажиллагаанд тавигдах шаардлагууд

Бараа бүтээгдэхүүнийг “шууд импортлоход” тавигдах шаардлага гэдгийг юу гэж ойлгох вэ?

Бараа бүтээгдэхүүнийг өөр улсын нутаг дэвсгэрээр дамжуулалтгүйгээр АХХБО-оос шууд Америкийн Нэгдсэн Улс руу тээвэрлэх, эсвэл өөр улсын нутаг дэвсгэрээр дамжуулсан тохиолдолд тухайн бараа нь Америкийн Нэгдсэн Улс руу тээвэрлэгдэж байх замдаа дамжин өнгөрч буй улсын худалдааны хилээр извтэрсэн байх ёсгүй юм. Бүх тохиолдлуудад нэхэмжлэх, тээврийн баримт бичиг болон тээвэрлэлтгэй холбоотой холбогдох бусад бичиг баримтуудад Америкийн Нэгдсэн Улсыг тухайн барааны хүрэх эцсийн газар гэж тэмдэглэсэн байх ёстой.

АНУ-ын ХЕС-үүдэд бус нутгийн холбооны (дын) гишүүн ашиг хүртэгч хөгжисэж буй орнуудад зориулсан тусгай заалтууд байдаг уу?

Байгаа. Бус нутгийн холбоодын гишүүд хүсэлт гаргаж, түүний үндсэн дээр тэднийг ХЕС-ийн дагуу бус нутгийн холбоод хэмээн хүлээн зөвшөөрсөн бол ХЕС-ийн гарал үүслийн шаардлагын үүднээс тухайн холбоог нэг улс гэж авч үзүэ. Холбооны гишүүн улсууд хамтдаа гарал үүслийн шаардлагыг биелүүлж байх юм бол тухайн холбооны ХЕС-д хамрагдах хоёр буюу түүнээс олон тооны гишүүн улсуудад үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнүүдийг гаалийн татвараас чөлөөлдөг. Тухайн бараа бүтээгдэхүүнийг аль нэг НБХХБО-оос АНУ шууд импортлон авч буй хугацаанд гагцхүү НБХХБО-оос импортолсон нөхцөлд гаалийн татвараас чөлөөлдөг бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх явцад бус нутгийн холбооны гишүүн АХХБО ба НБХХБО-ны хооронд уг бүтээгдэхүүний хуриимтлал үүсч болно.

Хэрэгцээний хягзаарлалтыг тухайн холбоонд бүхэлд нь хамааруулж бус зөвхөн бүтээгдэхүүний гарал үүслийг тогтоохын тулд л үнэлнэ. Фөрийнх нь ХЕС-д хамрагддаг гишүүн улсууд дээрх заалтын дагуу ашиг хүртэх боломжтой зургаан холбоо байдаг. Эдгээрт Бус нутгийн хамтын ажиллагааны Өмнөд Азийн Холбоо (SAARC), Андын Бүлэг (буюу Картагенийн Хэлэлцээрт нэгдэн орсон улсууд), Зүүн Өмнөд Азийн улсуудын холбоо (ASEAN), Карибийн иэгдсэн зах зээл (CARICOM), Өмнөд Африкийн хөгжлийн хамтын нийгэмлэг (SADC) болон Баруун Африкийн эдийн засаг, валютын холбоо (WAEMU) нар хамаарна.

7. Гар аргаар үйлдвэрлэсэн бөс даавуун бүтээгдэхүүн

Гар аргаар үйлдвэрлэсэн бөс даавуун бүтээгдэхүүний баталгаат зохицуулалт гэж юу вэ?

ХЕС-д хамрагдан ашиг хүртэгч улс тухайн тодорхой бараа бүтээгдэхүүн нь гар аргаар үйлдвэрлэгдсэн гэдгийг баталгаажуулж гэрчилгээжүүлэх асуудлаар Америкийн Нэгдсэн Улстай гэрээ байгуулсан бол зарим нэр төрлийн гар хийцийн бүтээгдэхүүнүүдийг ХЕС-д хамруулах боломжтой. Эдүгээг хүртэлх хугацаанд дээрх төрлийн гэрээ хэлэлцээрийг ашиг хүртэгч дараахь 13 улстай байгуулсан. Үүнд: Афганистан, Аргентин, Ботсван, Колумб, Египет, Йордан, Непал, Пакистан, Перу, Тайланд, Тунис, Турк ба Уругвай багтдаг.

Гар аргаар үйлдвэрлэсэн бөс даавуун бүтээгдэхүүний баталгаат зохицуулалтад хамаарах ямар нэр төрлийн бүтээгдэхүүнүүд байдаг вэ?

Энэхүү зохицуулалтаар ашиг хүртэгч улсын баталгаажуулж гэрчилгээжүүлсэн бөгөөд Америкийн Нэгдсэн Улс руу импортолсон дараахь нэр төрлийн бүтээгдэхүүнийг гаалийн татвараас чөлөөлөх эрхийг Нэгдсэн Улсад олгодог. Үүнд: гараар нэхсэн буюу ардын урлагийн чиглэлийн хананд өлгөх зориулалттай эд зүйлс (HTS 6304.99.10); гараар нэхсэн буюу ардын урлагийн чиглэлийн дэрнийн уут (HTS 6304.99.40); зарим нэр төрлийн гараар нэхсэн аравч (5805.00.20); гараар нэхсэн буюу ардын урлагийн чиглэлийн гурван нэр төрлийн хивс, хивсэнцэр болон шалан дээр дэвсэх зориулалттай бусад нэр төрлийн нэхээсэн эдлэл (5701.10.13, 5702.10.10, and 570.91.20); ба гар аргаар үйлдвэрлэсэн бөс даавуун материал (HTS 5208.31.20, HTS 5208.32.10, HTS 5208.41.20, HTS 5208.42.10, HTS 5208.51.20, HTS 5208.52.10, HTS 5209.31.30, HTS 5209.41.30 and HTS 5209.51.30) тус тус багтана.

Дээрх нэр төрлийн бүтээгдэхүүнийг импортлоход хийгдэх Гаалийн бүрдүүлэлт болон бичиг баримтын бүрдүүлэлтийн тусгай ажиллагааг дор тайлбарлав.

ХЕС-ийн дагуу гаалийн татвараас чөлөөлөгдохийн тулд ХЕС-д хамрагдах бүтээгдэхүүнийг гаалиар нэвтрүүлэхэд бичиг баримтын тусгай бүрдүүлэлт хийх шаардлагатай юу?

Гар аргаар үйлдвэрлэсэн, ХЕС-ийн дагуу гаалийн татвараас чөлөөлөгдөх баталгаажсан бүтээгдэхүүнийг гаалиар нэвтрүүлэхийн тулд уг бүтээгдэхүүнийг жинхэнэ гэдгийг батлах гурвалжин хэлбэртэй дардасыг түүний нэхэмжлэх дээр дарсан байх ёстой. Дээр дурдсанчлан АНУ-ын Засгийн газартай албан ёсны захидлуудыг харилцан солилцож ажиллагааг гүйцээсэн ашиг хүртэгч хөгжиж буй оронд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг л ХЕС-д хамруулдаг. Нэмэлт мэдээлэл авах хүсэлтэй бол Гаалийн албанд хандан уу.

Гар аргаар үйлдвэрлэсэн, ХЕС-д хамрагдах бүтээгдэхүүнийг уг нөхцөлд хамруулах хүсэлтийг импортлогч хэрхэн гаргах вэ?

Хилээр нэвтрүүлэх барим бичигт буй БУС-ийн тарифийн дугаарын өмнө “А” тэмдэг тавьснаар л үүнийг бүрэн гүйцэтгэж болно.

8. Бусад асуудлууд

ХЕС олгох хөтөлбөрийн хугацаа дуусч, хожим нь түүнийг буцаан хэрэглэх боломжтой тохиолдолд уг нөхцлийг дуусгавар болсны дараа буюу түүнийг дахин сэргээхээс өмнөх хугацаанд төлөгдсөн тарифийг импортлогч хэрхэн буцаан авч болох вэ?

Тухайн импортын худалдааг хийж байх үед ХЕС хүчин төгөлдөр байсан бол импортлогч хүсэлтээ электрон хэлбэрээр илгээхдээ ХЕС-д хамрагдах уг бүтээгдэхүүний тарифийн дугаарын өмнө ТХТТ буюу “А” тэмдгийг тавих ёстай. АНУ-ын Гаалийн ба хилийн хамгаалалтын алба ХЕС-д хамрагдах бүтээгдэхүүнийг импортоор оруулахад төлөгдсөн гаалийн татварыг хүсэлт гаргаж буй этгээдээр нэмэлт ажиллагаа хийлгэхгүйгээр цаг алдалгүй буцаан олгох зохицуулалтыг хийсэн байдаг. Одоогоор хэрэглэгдэж буй ТХТТ-ийг ашигласнаар импортлогч гаалийн татвараа буцаан авах боломжтой болно. Түүнийг хэрэглэхгүйгээр баримтаа бүрдүүлсний үндсэн дээр төлөгдсөн гаалийн татварыг буцаан авахдаа хүсэлтээ голчлон бичгээр гаргах ёстай.

(Нэмэлт мэдээллийг дараах вэб сайтаас үзнэ үү
<http://www.customs.gov/xp/cgov/home.xml>).

ХЕС олгох хөтөлбөрийг өөр улсууд хэрэгжүүлдэг үү?

Тийм ээ. Аж үйлдвэржсэн бусад 25-аас дээш тооны улсууд энэ хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Уг нөхцлийг олгож буй улсуудаас хамааран ашиг хүртэгч этгээдүүд, хамарагдах бүтээгдэхүүний нэр төрөл ба олгох нөхцлийн хэлбэр өөр өөр байдаг.

ХЕС олгох хөтөлбөртэй холбоотой Холбооны бүртгэлийн албаны мэдээллийг хаанаас олж үзэж болох вэ?

Холбооны бүртгэлийн албаны мэдээллийг АНУХТГ-ын <http://www.ustr.gov> гэсэн сайтаас татаж үзэж болно.

ХЕС-Д ХАМРАГДАХ УЛС ОРОН БА БАРАА БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТАЛААРХ БОЛОН УГ ХӨТӨЛБӨРТ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ЖУРАМТАЙ ХОЛБООТОЙ МЭДЭЭЛЭЛ

ХЕС-д хамрагдах ашиг хүртэгч орнууд

Тусгаар улсууд

Дараахь тусгаар тогтиносон улсууд ХЕС-д хамрагдаж ашиг хүртэх орнууд (АХХБО-үүд)-ын тоонд багтдаг. Үүнд:

Афганистан	Зүүн Тимор	Мали
Албани	Эквадор	Мавритан
Алжир	Египет	Маврити
Ангол	Экваторын Гвиней	Молдов
Аргентин	Эритрей	Монгол
Армени	Эфиоп	Мозамбик
Бангладеш	Фиджи	Намиб
Белиз	Габон	Непал
Бенин	Гамби	Нигер
Бутан	Гурж	Нигери
Болив	Гана	Оман
Босни Герцеговин	Гренад	Пакистан
Ботсван	Гвиней	Панам
Бразил	Гвиней-Биссау	Папуа-Шинэ Гвиней
Буркина Фасо	Гайана	Парагвай
Бурунди	Гаити	Перу
Камбож	Энэтхэг	Филиппин
Камерун	Индонез	Оросын Холбооны Улс
Капе Верде	Ирак	Руанда
Төв Африкийн Бүгд	Ямайк	Сент Киттс ба Невис
Найрамдах Улс	Йордан	Сент Люси
Чад	Казахстан	Сент Винсент ба
Колумб	Кени	Гренадин
Коморын арлууд	Кирибати	Самоа
Конго (Браззавиль)	Киргизстан	Сан Томе ба Принсипи
Конго (Киншаса)	Ливан	Сенегал
Коста Рика	Лесото	Серб ба Монтенегро
Кот д'Ивуар	Либери	Сейшель
Хорват	Македон, өмнө нь	Сьерра Леон
Жибути	Югославын Бүгд	Соломоны арлууд
Доминик	Найрамдах Улс байсан	Сомали
Доминиканы Бүгд	Мадагаскар	Өмнөд Африк
Найрамдах Улс	Малави	Шри Ланк

Суринам	Тунис	Вануату
Свазилэнд	Турк	Венесуэл
Танзани	Тувалу	Йемений Бүгд
Тайланд	Уганда	Найрамдах Улс
Того	Украин	Замби
Тонга	Уругвай	Зимбабве
Тринидад ба Тобаго	Узбекистан	

Тусгаар бус улсууд ба нутаг дэвсгэрүүд

Тусгаар бус дараахь улсууд ба нутаг дэвсгэрүүд ХЕС-д хамрагдаж ашиг хүртэх орнуудын тоонд багтдаг. Үүнд:

Ангуилла	(Ислас Мальвинас)	Туркс ба Кайкосийн
Энэтхэгийн далай дахь	Гибралтар	арлууд
Британийн эзэмшил	Хердийн арал ба	Виржиний арлууд,
нутаг дэвсгэр	Макдональдийн арлууд	Британийн Уоллис ба
Кристмасийн арал (Австрали)	Монтсеррат	Футуна
Кокосийн арлууд (Килинг)	Ниуей	
Кукийн арлууд	Норфолкийн арал	Баруун эрэг ба Газийн зуовас
Фолкландийн арлууд	Питкейрний арлууд Сент Хелена	Баруун Сахар
	Токелау	

Нэн буурай хөгжилтэй хөгжиж буй ашиг хүртэгч орнууд

Нэн буурай хөгжилтэй хөгжиж буй ашиг хүртэгч орнууд (НЕХХБАХО-үүд)-ад дараахь улсууд хамаарна. Үүнд:

Афганистан	Зүүн Тимор	Непал
Ангол	Экваторын Гвиней	Нигер
Бангладеш	Эфиоп	Руанда
Бенин	Гамби	Самоа
Бутан	Гвиней	Сан Томе ба Принсили
Буркина Фасо	Гвиней-Биссау	Сьерра Леон
Бурунди	Гаити	Сомали
Камбож	Кирибати	Танзани
Капе Верде	Лесото	Того
Төв Африкийн Бүгд	Либери	Тувалу
Найрамдах Улс	Мадагаскар	Уганда
Чад	Малави	Вануату
Коморын арлууд	Мали	Йемений Бүгд
Конго (Киншаса)	Мавритан	Найрамдах Улс
Жибути	Мозамбик	Замби

Улсуудын холбоо (ХЕС-ийн гарал уүслийн шаардлагын дагуу нэг улсад тооцогддог)

<u>Картагенийн</u>	<u>-ны зарим гишүүн</u>
<u>Хэлэлцээрийн гишүүн орнууд (Андын Бүлэг)</u>	<u>орнууд</u>
Болив	Бангладеш
Колумб	Бутан
Эквадор	Энэтхэг
Перу	Непал
Венесуэл	Пакистан
	Шри Ланк
<u>Баруун Африкийн эдийн засаг, валютын холбоо (WAEMU)-ны гишүүн орнууд</u>	<u>Өмнөд Африкийн хөгжлийн хамтын нийгэмлэг (SADC) -ны зарим гишүүн орнууд</u>
Бенин	Ботсван
Буркина Фасо	Маврити
Кот д Ивуар	Танзани
Гвиней-Биссау	
Мали	<u>Карибийн иэгдсэн зах зээл (CARICOM)-ийн гишүүн орнууд</u>
Нигер	Белиз
Сенегал	Доминик
Того	Гренад
<u>Зүүн Өмнөд Азийн улсуудын холбоо (ASEAN)-ны зарим гишүүн орнууд</u>	Гайана
Камбож	Ямайк
Индонез	Монтсеррат
Филиппин	Сент Киттс ба Невис
Тайланд	Сент Люси
	Сент Винсент ба Гренадин
	Тринидад ба Тобаго

Бүс нутгийн хамтын ажиллагааны Өмнөд Азийн Холбоо (SAARC)

ХЕС-д хамрагдахад тавигдах шаардлагууд

Заавал биелүүлэх шаардлагууд

ХЕС-ийн тухай дүрмийн 19 USC-ийн 2462(b)(2) дахь заалтад ХЕС-д хамрагдахаас өмнө сонирхогч улс бүр заавал биелүүлэх учиртай шаардлагуудыг дурдсан байдаг. Зөвхөн мэдээлэл өгөх зорилгоор тэдгээр шаардлагуудыг дор тоймлож бичлээ. Агуулгыг бүрэн эхээр нь үзэхийг хүсвэл ХЕС-ийн тухай дүрмийг харна уу.

- 1) ХЕС-д хамрагдах ашиг хүртэгч нь Худалдааны ердийн харилцааны журмаар бусад орнуудтай харьцдаг, Дэлхийн худалдааны байгууллагын буюу Олон улсын валютийн сангийн гишүүн бөгөөд олон улсын коммунист үзэл баримтлалд автаагүйгээс бусад тохиолдолд коммунист дэглэмтэй улс байж болохгүй;
- 2) ХЕС-д хамрагдах ашиг хүртэгч нь дараах нөлөө үзүүлэхүйц, улсуудын тохиролцоонд нэгдэн орох буюу үйл ажиллагаанд оролцсон байж буюу оролцож болохгүй. Үүнд: (а) олон улсын худалдааны эргэлтэд буй амин чухал хэрэгцээний нөөц баялгийг зогсоох, саатуулах, эсвэл тэдгээр нөөц баялгийн үнийг бодит бус түвшинд хүргэх болон (б) дэлхийн эдийн засагт ноцтой сүйрэл учруулах;
- 3) ХЕС-д хамрагдах ашиг хүртэгч нь аль нэг хөгжингүй орны, Америкийн Нэгдсэн Улсын худалдаанд ноцтойгоор сөргөөр нөлөөлж буй, эсвэл тийнхүү нөлөөлж болох бараа бүтээгдэхүүнд давуу эрх олгосон байж үл болно;
- 4) Ашиг хүртэгч нь зохих хэмжээний, ашиглаж, хэрэглэж болохуйц нөхөн олговрыг хурдан шуурхай олгох, эсвэл тийнхүү олгоход чиглэсэн арга хэмжээ авалгүйгээр, эсвэл тухайн маргааныг талуудын тохиролцож сонгосон арбитрийн байгууллагаар шийдвэрлүүлэхээр өгөлгүйгээр АНУ-ын иргэн буюу корпорацийн өмч хөрөнгийг нийгэмчилсэн, хураан авсан буюу бусад хэлбэрээр булаасан байж болохгүй;
- 5) ХЕС-д хамрагдах ашиг хүртэгч нь АНУ-ын иргэн буюу корпорацийн талд гарсан арбитрийн шийдвэрийг үл хүлээн зөвшөөрсөн, эсвэл түүнийг биелүүлээгүй байж болохгүй;
- 6) ХЕС-д хамрагдах ашиг хүртэгч нь олон улсын террорист үйл ажиллагаа явуулсан хувь хүн буюу бүлэг этгээдэд мөрдөн байцаалт явуулах, ял оногдуулахаас оргон зайлах боломж олгох замаар туслалцаа үзүүлсэн, эсвэл тэдний гар хөл болсон байх ёсгүй;

- 7) ХЕС-д хамрагдах ашиг хүртэгч нь олон улсад нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн дараахь хөдөлмөрчдийн эрх, нөхцлүүдийг олгох арга хэмжээ авсан, эсвэл авахаар тодорхой алхам хийсэн байх ёстой.
Үүнд: 1) эвлэлдэн нэгдэх эрх, 2) хамтын хүчээр зохион байгуулах болон хэлцэл хийх эрх, 3) албадан хөдөлмөр хийхээс татгалзах эрх, 4) хүүхдийн хөдөлмөр эрхлэх насын доод хязгаар, болон 5) цалингийн доод хэмжээ, ажиллах цаг ба хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндтэй холбоотой хүлээн авах бололцоотой нөхцлүүд; болон
- 8) ХЕС-д хамрагдах ашиг хүртэгч нь хүүхдийн хөдөлмөрийн хортой хэлбэрүүдийг устгах чиглэлээр авч буй арга хэмжээгээ цаашид үргэлжлүүлэх ёстой.

Сайн дураар биелүүлэх шаардлагууд

ХЕС-ийн тухай дүрмийн 19 USC-ийн 2462(c) заалтад ХЕС олгох хөтөлбөрийн зорилгоор тухайн орныг хөтөлбөрөөс ашиг хүртэгч улсаар тодорхойлохын тулд Ерөнхийлөгчийн зүгээс зайлшгүй харгалzan үзэх дараахь шалгууруудыг тооочсон. Зөвхөн мэдээлэл өгөх зорилгоор тэдгээр шаардлагуудыг дор тоймлож бичлээ. Агуулгыг бүрэн эхээр нь үзэхийг хүсвэл ХЕС-ийн тухай дүрмийг харна уу.

- 1) ХЕС олгох хөтөлбөрөөс ашиг хүртэгч улс болох хүсэлтээ илэрхийлсэн байх;
- 2) Нэг хүнд ногдох ҮНБ-ий хэмжээ, өөрийн улсын оршин суугчдын амьжиргааны түвшин болон Ерөнхийлөгчийн зүгээс харгалzan үзэх гаардлагатай хэмээн үзсэн эдийн засагтай холбогдсон бусад хүчин зүйлс зэрэг эдийн засгийн чиглэлийн хөгжлийн түвшинтэй холбоотой мэдээллүүд;
- 3) Хүсэлт гаргаж буй улсад хөгжингүй гол бусад орны зүгээс давуу эрх бүхий тарифийн ерөнхий нөхцөл олгож байгаа эсэх;
- 4) Хүсэлт гаргаж буй улс Америкийн Нэгдсэн Улсад хувь тэнцүүлэх зарчмаар, бодитойгоор өөрийн зах зээлд нэвтрэх болон хэрэглээний гол нөөц баялгаасаа худалдан авах боломжийг олгоно гэдэг талаар Нэгдсэн Улсад хэр зэрэг нухацтай бөгөөд баттай итгэл үнэмшил төрүүлсэн, түүнчлэн экспортын зохисгүй практикийг хэрэгжүүлэхээс татгалзах талаар Нэгдсэн Улсыг хэр зэрэг баттай үнэмшүүлсэн;
- 5) Хүсэлт гаргаж буй улс патент, барааны тэмдэг болон зохиогчийн эрх зэрэг оюуны өмчийг хэр зэрэг зүй зохистой бөгөөд үр дүнтэй хамгаалж байгаа;

- 6) Хүсэлт гаргаж буй улс экспортын гүйцэтгэлийн шаардлага зэрэг худалдааны ёс журмыг алдагдуулсан хөрөнгө оруулалтын практик болон бодлогыг хэрэгжүүлэх явдлыг багасгах, түүничлэн үйлчилгээний худалдааны хориг саадыг угүй болгох чиглэлээр авч арга хэмжээний хэр хэмжээ; болон
- 7) Тухайн орон олон улсад нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн дараахь хөдөлмөрчдийн эрх, нөхцлүүдийг олгох арга хэмжээ авсан, эсвэл авахаар тодорхой алхам хийсэн эсэх: 1) эвлэлдэн нэгдэх эрх, 2) хамтын хүчээр зохион байгуулах болон хэлцэл хийх эрх, 3) албадан хөдөлмөр хийхээс татгалзах эрх, 4) хүүхдийн хөдөлмөр эрхлэх насын доод хязгаар, болон 5) цалингийн доод хэмжээ, ажиллах цаг ба хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндтэй холбоотой хүлээн авах бололцоотой нөхцлүүд.

1995 оны 1-р сарын 1-ний өдрийн байдлаар Америкийн Нэгдсэн Улсад үйлдвэрлэгдэж байгаагүй бараа бүтээгдэхүүний нэр төрөл

19 USC-ийн 2463(c)(2)(e) заалтаар тухайн бүтээгдэхүүнтэй ижил төстэй буюу түүнтэй шуд өрсөлдөхүйц зарим нэр төрлийн бараа бүтээгдэхүүн 1995 оны 1-р сарын 1-ний өдрийн байдлаар Америкийн Нэгдсэн Улсад үйлдвэрлэгдэж байгаагүй тохиолдолд тэдгээрийг өрсөлдөөнт хэрэгцээний хязгаарлалтаас чөлөөлөхөөр хуульчилсан. 19 USC-ийн 2463(c)(2)(A)(i)(II) дахь заалтад дурдсан өрсөлдөөнт хэрэгцээний хязгаарлалтаас чөлөөлөх нөхцөл ёсоор зохих татварын чөлөөлөлтийг эдлүүлээгүй байгаа тохиолдолд уг хуанлийн жилийн туршид тухайн нэр төрлийн бүтээгдэхүүний АНУ руу нийлүүлсэн импортын хэмжээ нь Нэгдсэн Улсын уг бүтээгдэхүүний нийт импортын үнэлгээний 50%-иас дээш хэмжээнд хүрсэн, эсвэл 503(c)(1)(A)(i)(II) заалтад буй томъёогоор илэрхийлэгдсэн тухайн бүтээгдэхүүний америк доллараар тогтоосон үнэлгээг (2005 онд 120 сая америк доллар байсан бөгөөд дараагийн жил тутам 5 сая доллараар нэмэгдэх учиртай) давсан бол түүний дараагийн хуанлийн жилийн 7-р сарын 1-ний өдрөөс уг бүтээгдэхүүний гаалийн татвараас чөлөөлөгдөх нөхцөл дуусгавар болох юм.

ХЕС-ийн нөхцлийг хэрэгжүүлэхдээ ХБАХАХ (Ерөнхийлөгчийн тогтоосны дагуу) тодорхой нэр төрлийн бараа бүтээгдэхүүнийг 1995 оны 1-р сарын 1-ний өдрийн байдлаар Америкийн Нэгдсэн Улсад үйлдвэрлэгдээгүй байсан гэдгийг БҮС-ийн дор дурдсан дэд гарчигийн дагуу авч үзинэ. Үүнд:

0305.59.20	2208.90.12	3926.20.20	7615.20.00
0406.10.10	2208.90.14	3926.90.70	8446.21.00
0501.00.00	2208.90.15	4206.10.30	8447.20.10
0502.10.00	2208.90.55	4601.20.20	8447.20.60
0505.90.00	2208.90.72	4602.10.11	8448.51.10
0510.00.20	2306.60.00	4602.10.13	8452.10.00
0709.90.10	2401.10.40	4807.91.00	8525.20.15
0710.90.10	2402.20.10	4823.90.50	8527.11.11
0712.90.15	2402.20.90	5301.21.00	8714.93.10
0803.00.40	2504.10.10	5701.10.13	8714.93.60
0807.10.50	2805.22.10	5702.10.10	8714.94.25
0811.90.25	2904.10.04	5702.91.20	8714.94.40
0908.20.20	2907.15.30	5805.00.20	9101.12.80
1207.91.00	2908.20.08	5904.10.00	9101.91.20
1211.90.60	2908.20.15	6304.99.10	9101.91.40
1302.12.00	2912.30.50	6304.99.40	9101.91.80
1401.20.40	2912.50.00	6402.20.00	9101.99.20
1504.30.00	2914.61.00	6502.00.60	9101.99.40
1515.30.20	2918.13.10	6703.00.30	9101.99.60
1515.50.00	2918.13.20	6802.91.30	9101.99.80
1602.50.10	2918.23.10	6812.50.50	9102.12.80
1904.90.00	2922.29.23	7004.10.10	9102.91.20

2001.90.10	2922.30.14	7004.10.50	9102.99.20
2001.90.33	2924.29.04	7004.90.50	9102.99.40
2001.90.42	2924.29.42	7006.00.20	9102.99.60
2001.90.50	2925.20.15	7013.10.10	9102.99.80
2005.90.87	2926.90.17	7016.10.00	9105.99.10
2008.30.54	2933.51.10	7103.10.40	9202.90.20
2008.91.00	3205.00.20	7103.99.50	9405.91.10
2008.99.15	3301.29.10	7104.10.00	9502.10.60
2008.99.63	3301.29.20	7104.90.10	9502.99.10
2008.99.65	3806.20.00	7116.20.20	9617.00.40
2208.20.10	3808.10.10	7215.90.50	

**Хэрэгцээний хягзаарлалтаас чөлөөлөгдсөн бараа
бүтээгдхүүний иэр төрөл ба улс орнууд**

БУС хувваарын төв тодорхойлолт	Улс	Он
0603.10.30 Шинэхэн тайрсан лиши цэцэг	Колумб	1989
0714.90.20 Шинэхэн буюу хөргөсөн амтат төмс, зүссэн байдалтай буюу үрэл хэлбэртэй	Колумб	1989
0802.90.94 Коланы самар, хальсалсан хэлбэрээр бэлдсэн шинэхэн буюу хатаасан	Кот д Ивуар	1997
1202.20.40 Газрын самар, шарсан буюу чанаж бэлдээгүй, хальсалсан, 12-р бүлгийн АНУ-ын 2-р тайлбарын хавсралтад зааснаар	Аргентин	2003
1602.41.20 Гахайн давсалсан мах, хэрчсэн, үр тариа, буудай болон ногоогүй, яснаас нь салгасан, агааргүйгээр савласан	Польш	1991
1604.30.20 Загасны түрс	ОХУ	1998
1701.11.05 Чихрийн нишингэ, түүхийгээр, хатуу хэлбэртэй, нэмэлт амт ба өнгө нэмээгүй, БУС-ийн 15-р ерөнхий тайлбарт нийцсэн	Колумб	1989
1701.11.05 Чихрийн нишингэ, түүхийгээр, хатуу хэлбэртэй, нэмэлт амт ба өнгө нэмээгүй, БУС-ийн 15-р ерөнхий тайлбарт нийцсэн	Филиппин	1989
1701.11.10 Чихрийн нишингэ, түүхийгээр, хатуу хэлбэртэй, нэмэлт амт ба өнгө нэмээгүй, 17-р бүлгийн АНУ-ын 5-р хавсралтад зааснаар	Колумб	1989
1701.11.10 Чихрийн нишингэ, түүхийгээр, хатуу хэлбэртэй, нэмэлт амт ба өнгө нэмээгүй, 17-р бүлгийн АНУ-ын 5-р хавсралтад зааснаар	Филиппин	1989
1701.11.20 Чихрийн нишингэ, түүхийгээр, хатуу хэлбэртэй, зарим төрлийн полигидрат согтууруулах ундаанд хэрэглэх	Колумб	1989
1701.11.20 Чихрийн нишингэ, түүхийгээр, хатуу хэлбэртэй, зарим төрлийн полигидрат согтууруулах ундаанд хэрэглэх	Филиппин	1989
2008.11.25 Хальсыг нь авсан газрын самар, 12-р бүлгийн АНУ-ын 2-р тайлбарын хавсралтад зааснаар, ЖН 15-ын дагуу бус	Аргентин	2003
2008.99.15 Гадил жимс, нухаш хэлбэртэйгээс бусад, өөр хэлбэрээр бэлтгэж, дарсан, неси хэлбэрээр	Филиппин	1989

БУС хуваарлалт	Товч тодорхойлолт	Улс	Он
2008.99.28	Инжир жимс, өөр хэлбэрээр бэлтгэж, дарсан, неси хэлбэрээр	Колумб	1989
2836.91.00	Литийн нүүрсхүчлийн давс (литийн карбонат)	Чили	1992
2841.70.10	Аммиакийн молибдийн давс	Чили	1999
2849.90.50	Карбид, несол хэлбэртэй	Өмнөд Африк	1999
2905.11.20	Метанол (Метил алкоголь), синтетик байгалийн хий үйлдвэрлэх зориулалтаар буюу шууд түлш болгон ашиглахаар импортолсноос бусад	Венесуэл	1997
2909.19.14	Метил тертий-бутилийн эфир	Венесуэл	1997
2915.70.00	Пальмитины хүчил, стеарины хүчил, тэдгээрийн давс ба нийлмэл эфир	Филиппин	1989
2915.90.10	Амтыны болон ургамлын гаралтай өөхний хүчил, несол хэлбэртэй	Филиппин	1989
2916.31.10	Бензолын хүчил болон түүний давс ба нийлмэл эфир, несол хэлбэртэй	Эстони	1999 (анх олгосон дугаар нь 2916.31.15 болно)
2917.37.00	Терефталатын диметил	Румын	1997
2933.39.25	Гербицидийн несой, зөвхөн азотын гетероатом агуулсан гетероцикл нэгдлийн, пиридиний уусаагүй цагариг бүхий Зөвхөн азотын гетероатом агуулсан гетероцикл нэгдлийн хортонтой тэмцэх хэрэгсэл, цаашид уусахгүй хинолины буюу изохинолины цагаргин тогтолцоотой нэгдэл	Бразил	1997
2933.49.30	6-Гексанелактам (эпсилон-Капролактам)	Бразил	1997 (анх олгосон дугаар нь 2933.40.30 болно)
2933.71.00	Ацетилсульфизоксазол; сульфацетамидин натри; болон сульфаметазиний натри	OХУ	1998
2935.00.32	Ацетилсульфизоксазол; сульфацетамидин натри; болон сульфаметазиний натри	Хорват	1991
2935.00.32	Ацетилсульфизоксазол; сульфацетамидин натри; болон сульфаметазиний натри	Босни Герцеговин	1991
2935.00.32	Ацетилсульфизоксазол; сульфацетамидин натри; болон сульфаметазиний натри	Македон	1991
3503.00.55	Царцмаг ялтас ба үүсмэл нэгдэл, несол хэлбэртэй; гялтгануур; несол хэлбэртэй, амтыны гаралтай бусад төрлийн цавуу	Колумб	1989
3823.19.20	Аж үйлдвэрийн зориулалттай монокарбоксилийн өөхний хүчил болон кокос, далдуу модны үр, эсвэл далдуу модны тоосноос гарган авсан хүчиллэг тос	Филиппин	2005
3921.90.11	Хүний гараар бүтсэн мяндастай нийлүүлсэн эсийн бүтэцгүй пластикаас гарган авсан наалдамхай бус хавтан, ялтас, хальс, бүрхэвч, тууз, нягтишил нь 1.492 кг/м ² байх, 70-аас дээш % нь пластикаас бүтсэн	Колумб	1989

ЕУС куваад	Төв тодорхойлолт	Улс	Он
4107.19.40	Зэрлэг үхрийн шир, үсгүй, бүдүүн ширхэг, ноосноос болоод бөөгнөрсөн хэсгээс нь салгасан, бусад байдлаар илэг болгосон, эсвэл элдэж бэлдсэн байдлаар буй	Тайланд	1997 (анх олгосон дугаар нь 4104.39.20 болно)
4107.19.50	Үхрийн (зэрлэг үхэр биш) бүтэн шир, несои буюу эквинес несои хэлбэрээр, үсгүйгээр, элдсэн буюу элдээгүй байдлаар, 4114-т заасан байдлаар бус	Аргентин	2005
4107.92.80	Үхрийн (зэрлэг үхэр биш) бүдүүн ширхэгтэй шир буюу адууны шир, бүтнээрээ бус, үсгүйгээр, элдсэн буюу элдээгүй байдлаар, 4114-т заасан байдлаар бус	Аргентин	2005
4107.99.40	Зэрлэг үхрийн шир, үсгүй, бүдүүн ширхэг, ноосноос болоод бөөгнөрсөн хэсгээс нь салгасан, бусад байдлаар илэг болгосон, эсвэл элдэж бэлдсэн байдлаар буй	Тайланд	1997 (анх олгосон дугаар нь 4104.39.20 болно)
4113.90.60	Амьтдыг шир, неси байдлаар, үсгүйгээр, илгийг оролцуулахгүйгээр, патенттай, патенттай давхар үетэй, эсвэл металлаар бүрсэн ёндөр чанаарын	Өмнөд Африк	1997 (анх олгосон дугаар нь 4107.90.60 болно)
4203.21.20	Арсаар, эсвэл дууриамал арьсаар хийсэн спортын бээлий	Индонез	1997
4412.13.40	Хавтгай фанер, 6 мм-ээс багагүй зузаантай, гаднах уе нь тропикийн бүсийн тусгай modoор хийсэн, нүүрэн тал нь несои хэлбэрийн, нэвт харгдах / тунгалааг үеийн наагуур өөр давхаргаар үелээгүй	Индонез	2005
4602.10.16	Ротанг, эсвэл далдуу модны навчаар хийсэн сагс, гар цүнх, несои хэлбэрийн	Филиппин	1989
4602.10.18	Ургамлын зүйлээр хийсэн сагс, гар цүнх, несои хэлбэрийн	Филиппин	1989
4602.10.80	Несои хэлбэрийн ургамлын зүйлээр сүлжиж хийсэн эдлэлүүд, несои хэлбэрийн	Филиппин	1989
6702.90.65	Хиймэл цэцэг, навч, жимс зэрэг зүйлс, хиймэл цэцгэн эдлэлүүд, пластик, өд, цахилгаанждаг материалыас бусад зүйлээр урласан	Тайланд	1995
6905.10.00	Дээврийн керамик хавтан	Венесуэл	1997
7113.11.20	Мөнгөөр урласан гоёл чимэглэлийн зүйлс болон тэдгээрийн бүрдэл хэсгүүд, несои хэлбэрийн, 12 ширхэг нь буюу бүрдэл хэсэг нь 18 америк доллараас ихгүй үнэтэй	Тайланд	1995
7113.11.50	Мөнгөөр урласан гоёл чимэглэлийн зүйлс болон тэдгээрийн бүрдэл хэсгүүд, несои хэлбэрийн, 12 ширхэг нь буюу бүрдэл хэсэг нь 18 америк доллараас дээш үнэтэй	Тайланд	2005
7113.19.10	Үнэт эдлэл хийх зориулалт бүхий үнэт метал (мөнгөнөөс бусад)-аар хийсэн тасархай бус цувимал дээс, олс гэх мэт зүйлс, өөр төрлийн үнэт металлар бүрсэн буюу бүрээгүй байдлаар	Перу	1992

БУС хувьарх	Төвч тодорхойлолт	Үйлс	Он
7113.19.25	Хүзүүний монетон зүүлт ба гинж	Энэтхэг	2001
7113.19.29	Хүзүүний алтан зүүлт ба гинж (үргэлж дээс байдлаар бус, монетоор хийсэн бус)	Энэтхэг	2001
7113.19.29	Хүзүүний алтан зүүлт ба гинж (үргэлж дээс байдлаар бус, монетоор хийсэн бус)	Турк	2003
7113.19.50	Үнэт металл (мөнгөнөөс бусад)-аар хийсэн үнэт эдлэлийн зүйлс ба тэдгээрийн бүрдэл хэсгүүд, өөр төрлийн үнэт металлар бүрсэн буюу бүрээгүй байдлаар, несөн хэлбэрээр	Энэтхэг	2001
7113.19.50	Үнэт металл (мөнгөнөөс бусад)-аар хийсэн үнэт эдлэлийн зүйлс ба тэдгээрийн бүрдэл хэсгүүд, өөр төрлийн үнэт металлар бүрсэн буюу бүрээгүй байдлаар, несөн хэлбэрээр	Тайланд	1995
7113.19.50	Үнэт металл (мөнгөнөөс бусад)-аар хийсэн үнэт эдлэлийн зүйлс ба тэдгээрийн бүрдэл хэсгүүд, өөр төрлийн үнэт металлар бүрсэн буюу бүрээгүй байдлаар, несөн хэлбэрээр	Турк	2003
7202.50.00	Хромын тэмөрт силикон	ОХУ	2000
7202.50.00	Хромын тэмөрт силикон	Зимбабве	1993
7202.50.00	Хромын тэмөрт силикон	Казахстан	2003
7202.93.80	Тэмөрт ниобий, несөн хэлбэрээр	Бразил	2003
7202.99.10	Тэмөрт циркони	Бразил	2000
7403.13.00	Цэвэршүүлсэн зэсээр хийсэн саваа	Чили	1999
7403.19.00	Цэвэршүүлсэн зэс, давтаагүй, несөн хэлбэрийн	Чили	1999
7413.00.10	Зэс ороомог утас, цахилгаанаар ялгаж аваагүй, угсарч, тоноглоогүй, аливаа бүтээгдэхүүн болгоогүй	Перу	1992
7418.19.10	Зэсээр хийсэн, үнэт металлаар бүрсэн, ширээний, гол тогооны буюу гэр ахуйн эдлэл, эсвэл тэдгээрийн бүрдэл хэсгүүд	Энэтхэг	2001
7418.19.20	Зэс, цинкийн хайлш (гууль)-аар хийсэн, үнэт металлаар бүрээгүй, ширээний, гол тогооны буюу гэр ахуйн эдлэл, эсвэл тэдгээрийн бүрдэл хэсгүүд	Энэтхэг	1999
7418.19.50	Зэс (гууль биш)-эр хийсэн, үнэт металлаар бүрээгүй, ширээний, гол тогооны буюу гэр ахуйн эдлэл, эсвэл тэдгээрийн бүрдэл хэсгүүд	Энэтхэг	2003
8108.90.60	Титан, давтаагүй несөн хэлбэрийн	ОХУ	1998
8402.20.00	Өндөр халуунаар ус буцалгагч бойлер	Филиппин	1994
8407.34.18	8701.20 буюу 8702-8704 дугаарын тээврийн хэрэгсэлд зориулсан оч хаяж асдаг, ухрах, давших хөдөлгөөн хийх бүлүүрт хөдөлгүүр, цилиндрийн багтаамж нь 1000-аас дээш 2000 см3-ийн хооронд, шинэ	Бразил	1994
8407.34.48	8701.20 буюу 8702-8704 дугаарын тээврийн хэрэгсэлд зориулсан оч хаяж асдаг, ухрах, давших хөдөлгөөн хийх	Бразил	1994

БҮС хуваврь	Төвч тодорхойлолт	Удс	Он
	бүлүүрт хөдөлгүүр, цилиндрийн багтаамж нь 2000 см3-аас дээш, шинэ		
8409.91.30	8701.20 буюу 8702-8704 хүртэлх дугаарын тээврийн хэрэгсэлд зориулсан оч хаяж асдаг, дотоод шаталтат, бүлүүрт хөдөлгүүрийн хөнгөн цагаан цилиндрэн толгой Угсарч суурилуулдаг, адарт тогтоодог сэнс, өөрт нь суурилуулсан, 125 ваттаас ихгүй чадалтай цахилгаан мотортой	Бразил	1994
8414.51.30	Угсарч суурилуулдаг, адарт тогтоодог сэнс, өөрт нь суурилуулсан, 125 ваттаас ихгүй чадалтай цахилгаан мотортой	Тайланд	2003
8483.10.30	Хуваарилалтын бул ба тахир гол, неси хэлбэрийн	Бразил	1999
8525.40.80	Хөдөлгөөнгүй дүрс авах зориулалттай дүрс бичлэгийн хэрэгсэл (тоон системийнхээс бусад) болон дүрс бичлэгийн бусад хэрэгсэлүүд	Индонез	2004
8527.21.10	Радио хүлээн авагч бүхий, хуурцагтай тоглуулагч, гаднаас авах эрчим хүчтүүгээр ажилладагтүй, тээврийн хэрэгсэлд зориулсан	Бразил	1997
8527.31.40	Радио хүлээн авагч, хуурцагтай тоглуулагчтай, неси хэлбэрийн	Индонез	1997
8527.39.00	Неси хэлбэрийн радио хүлээн авагч, радиотелефон болон радиотелеграфийн долгион хүлээн авах чадалтай хэрэгсэл бүхий	Индонез	1999
8527.90.95	Радиотелефон болон радиотелеграфийн долгион хүлээн авах, радио долгион цацах хэрэгсэл, неси хэлбэрийн	Филиппин	1997
8528.12.28	Өндөр ялгаруулалттай өнгөгүй телевизийн долгион хүлээн авагч хэрэгсэл, туслалгүй, дүрс бичлэгийн хуурцаг бичигч, эсвэл тоглуулагчтай, дэлгээцийн диагоналийн хэмжээ нь 35.56 см-ээс дээш	Тайланд	2003
8529.90.01	Телевизийн долгион тохируулах давталтын хэвлэмэл хэрэгсэл	Индонез	1994
8529.90.29	Телевизийн хэрэгслийн долгион тохируулагч, давталтын хэвлэмэл хэрэгслээс бусад	Индонез	1994
8544.30.00	Тээврийн хэрэгсэл, нисэх болон усан онгоцонд зориулсан тусгаарлагдсан асаалтын сситетмэй цахилгаан утас татах болон утас татах бусад төрлийн хэрэгсэл	Филиппин	1991
8544.30.00	Тээврийн хэрэгсэл, нисэх болон усан онгоцонд зориулсан тусгаарлагдсан асаалтын сситетмэй цахилгаан утас татах болон утас татах бусад төрлийн хэрэгсэл	Тайланд	2003
8708.39.50	8701 дугаарын, неси хэлбэрийн болон 8702-8705 дугаарын тээврийн хэрэгслийн сэлбэг, хэрэгсэл, тоормосны буюу серво тоормосны систем болон тэдгээрийн сэлбэг хэрэгсэл (угсарч суурилуулсан тоомосны бүрээсээс бусад)	Бразил	1999
9001.30.00	Контакт линзүүд	Индонез	2005
9009.12.00	Цахилгаан статик хуулбарлах хэрэгсэл, эх дурсийг дамжуулан хуулбарлах зарчмаар ажилладаг (шууд бус хуулбар)	Тайланд	2005
9032.89.60	Өөрөө ажилладаг зохицуулах болон хянан шалгах хэрэгсэл, неси хэлбэрийн	Филиппин	1997
9405.50.20	Пропан буюу бусад төрлийн хийгээр, эсвэл шахаж савласан агаар буюу керосин, бензинээр ажилладаг, цахилгаанаар ажилладагтүй улайсч асдаг чийдэн	Энэтхэг	2003

БУС-н зорилт	Төвч тодорхойлолт	Улс	Он
9405.50.30	Цахилгаанаар ажилладаггүй чийдэн буюу гэрэлтүүлэх хэрэгсэл, несон хэлбэрийн, гуулиар хийсэн	Энэтхэг	2001
9405.50.40	Цахилгаанаар ажилладаггүй чийдэн буюу гэрэлтүүлэх хэрэгсэл, несон хэлбэрийн, гуулиар хийгээгүй	Энэтхэг	2003
9613.10.00	Янжуурын асаагуур буюу түүнтэй ижил төстэй асаагуур, хийгээр асдаг, цэнэглэдэггүй, халаасны	Филиппин	1989

ХЕС-д хамрагдахаар сонгогсдон ашиг хүртэгч улсын тус нөхцөлд хамаарахгүй бараа бүтээгдэхүүний нэр төрөл

ХЕС-д хамрагдахаар сонгогсдон ашиг хүртэгч улсын тус нөхцөлд хамаарахгүй бараа бүтээгдэхүүний нэр төрлүүдийг БУС-ийн дэд гарчигаар нь Америкийн Нэгдсэн Улсын Барааны Уялдуулсан Систем БУС-ийн Ерөнхий тайлбар хэсгийн GN 4(d) дэх хуудаст жагсааж бичсэн байдаг.
[\(<http://hotdocs.usitc.gov/docs/tata/hts/bychapter/0700gn.pdf>\)](http://hotdocs.usitc.gov/docs/tata/hts/bychapter/0700gn.pdf)

ХЕС-д хамрагдах хүсэлт гаргахтай холбоотой мэдээлэл

Ерөнхий зааврууд¹

ХЕС-д хамрагдах хүсэлт гаргахтай холбоотой заавруудын талаарх хамгийн чухал эх сурвалж бол Холбооны бүртгэл юм. Бараа бүтээгдэхүүн ба/эсвэл улсын практикт шалгалт хийсэн жилийн тайлангийн талаарх мэдээллүүдийг Холбооны бүртгэлд жил бүр хэвлэж тараадаг. Эдгээр мэдээлэл нь хүсэлтийн маягтын загвар, гаргах цаг хугацаа болон ХЕС-ийн асуудал хариуцсан дэд хороонд хүсэлтээ мэдүүлэх аргачлал зэргийн талаар заавал даган биелүүлэх ёстой тусгай заавруудыг агуулдаг. Хүсэлт гаргах үйл явцтай холбоотой ерөнхий заавруудыг дараахь байдлаар тоймлон бичив.Үүнд:

Маягтын загвар

ХЕС-д хамрагдахаар гаргах хүсэлтэд багтаасан байх мэдээллийн жагсаалтыг доороос үзинэ үү. Энэ нь (1) ХЕС-д хамрагдах бараа бүтээгдэхүүн ба улс орны жагсалтад нэмэлт, өөрчлөлт оруулах хүсэлт гаргахтай холбоотой ХЕС-ийн талаарх дүрэм, журамд заасан мэдээлэлд тавигдах шаардлагуудыг сонирхогч талууд биелүүлэхэд нь туслах; болон (2) нэмэлт, өөрчлөлт оруулахыг хүсэмжилж буй сонирхогч талуудад зааварчилгаа өгөх зорилготой юм. Эдгээр талууд нь дор жагсааж бичсэн мэдээллийг гаргаж өгөхөөсөө өмнө дээр дурдсан зааварт буй АНУ-ын ХЕС-ийн тухай албан ёсны дүрэм, журамтай танилцсан байх нь зүйтэй.

Дорх жагсаалтад дурдсан бүх мэдээллийг гаргаж өгөхийг ХЕС олгохтой холбоотой одоогоор хүчин төгөлдөр үйлчилж буй дүрэм, журмаар шаардаж байгаа юм. Хүсэлт гаргагч нь шаардагдаж буй мэдээллийг олж авахын тулд сайн санааны үүднээс хичээн зүтгэнээс бусад тохиолдолд шаардлагатай мэдээллүүдийн аль нэгийг оруулаагүй хүсэлтийг хүлээн авахаас татгалзана. Нууц байдлаар гарган өгөх мэдээлэлд тухайн материалыг нууц хэмээн ангилах болсон олон нийтэд тараах боломжгүй гэдгийн шалтгааныг тайлбарлан бичсэн салангид хуудсыг хавсаргах замаар тусгай тэмдэг тавьсан байх (бизнесийн холбогдолтой нууц мэдээллийг гарган өгөхтэй холбоотой дорх зааврын дагуу) ёстой.

Хүсэлт гаргагч бүх этгээдүүдэд зориулсан ерөнхий мэдээлэл

- Хүсэлт гаргагчийн нэр болон түүгээр төлөөлүүлж буй хувь хүн, пүүс буюу холбооны нэрийг бичих ёстой. ХЕС олгох хөтөлбөр хүсэлт гаргагчийн ашиг сонирхолт хэрхэн нөлөөлж буйг товчоор тайлбарлан бичнэ.
- Сонирхож буй бараа бүтээгдэхүүн буюу бараа бүтээгдэхүүнүүдийн нэр төрөл болон тэдгээрийн дэлгэрэнгүй тодорхойлолт, БУС-ийн дэд гарчиг зэргийг бичих шаардлагатай. Сонирхож буй бараа бүтээгдэхүүн буюу бараа бүтээгдэхүүнүүдийн нэр төрлийг БУС-ийн багцалсан бүлэгт хамааруулан өөр нэр төрлийн бүтээгдэхүүнүүдтэй хамт бичсэн бол сонирхож буй бараа бүтээгдэхүүн буюу бараа бүтээгдэхүүнүүдийн тодорхой нэр төрлүүдийн дэлгэрэнгүй тодорхойлолтыг бичнэ.
- Авахуулахыг хүсч буй арга хэмжээг шалтгаантай нь хамт тайлбарлан бичиж, холбогдох бусад мэдээллийн хамтаар ирүүлэх ёстой.
- Хүсэлт гаргагч нь мэдлэг, мэдээлэл бүрэн дайчилсны үндсэн дээр арга хэмжээ авахуулах гэж буй шалтгаан болон хүсэлтдээ бичсэн мэдээллийг өмнө нь өөрөө буюу өөр этгээдээр дамжуулан ХБАХАХ-нд гаргаж өгсөн эсэх тухай дурдах хэрэгтэй. Хүсэлт гаргагч хэрэв урьд нь хүсэлтээ тавьж, түүнийг нь хүлээн авахаас татгалзсан хариу авснаа мэдэж байгаа бол тэрбээр уг хүсэлтийг гаргаснаас хойшхи хугацаанд дахин хүсэлт гаргаж шийдвэрлүүлж болохуйц нөхцөл байдал шинээр үүссэн гэдгийг хүсэлтдээ хавсаргана. (Тухайн бүтээгдэхүүнийг ХЕС-д хамруулах тухай урьд нь гаргасан хүсэлтийг хуанлийн өмнөх гурван жилийн хугацаанд зохих байгууллага бүрэн хэмжээний шалгалт хийхээр албан ёсоор хүлээн авсан байх аваас уг бүтээгдэхүүнийг жагсаалтад шинээр оруулах хүсэлтийг хянан шийдвэрлэхээс татгалзах болно.) Өмнө нь гаргаж байсан хүсэлтийг талаарх мэдээллийг ХЕС-ийн мэдээллийн төвөөс үзэх боломжтой.
- Хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн тохиолдолд хүсэлт гаргагчийн хүртэж болох ашгийн талаарх мэдээллийг ирүүлнэ.

Нэмэлт мэдээлэл

Хүсэлтэд хавсаргаж ирүүлэх ёстой нэмэлт мэдээлүүдийг дорх хэсгээс үзинэ үү. Үүнд:

а. Тодорхой нэр төрлийн бараа бүтээгдэхүүнийг ерөнхий нөхцлөөс хасуулах, хязгаарлалт тогтоолгох болон хойшлуулах тухай хүсэлт гаргах

Тодорхой нэр төрлийн бараа бүтээгдэхүүнийг ерөнхий нөхцлөөс хасуулах, хязгаарлалт тогтоолгох болон хойшлуулахын тулд хүсэлт гаргахдаа хүсэлт гаргагчид АНУ-ын холбогдох аж үйлдвэрийн салбарын талаарх сүүлийн гурван жилийн дараах төрлийн мэдээллийг гарган өгөх ёстой. Мэдээллийг хүсэлт гарган шийдвэрлүүлэх гэж буй бараа бүтээгдэхүүний нэр төрөл

болов боломжтой нөхцөлд тухайн хүсэлт хамаарч байгаа аж үйлдвэрийн салбарын хоёулангийнх нь хувьд гарган өгөх учиртай.

- Пүүсүүдийн тоо болон байршил
- Бодит үйлдвэрлэлтэй холбоотой мэдээлэл
- Үйлдвэрлэлийн хүчин чадал ба уг хүчин чадлын ашиглалт
- Ажиллагсдын тоо, төрөл, цалин хөлсний хэмжээ, байршил болон эдгээр бүх мэдээлэлд гарсан өөрчлөлтүүд зэрэг хөдөлмөр эрхлэлттэй холбоотой мэдээлэл
- Борлуулалтын мэдээлэл (тоо хэмжээ, өртөг ба үнэ)
- Экспортлосон бүтээгдэхүүний тоо хэмжээ болон өртөг, түүнчлэн экспортын гол зах зээлүүд
- Боломжтой бол бүтээгдэхүүний нэр төрөл болгоны борлуулалтаас олж буй ашиг гэх мэт ижил төстэй бүтээгдэхүүн үйлдвэрлэгч пүүсүүдийн ашигт ажиллагааны талаарх мэдээлэл
- Бараа материалын, хөдөлмөрийн болон нэмэгдэл зардал зэрэг зардуудын шинжилгээ
- АНУ-ын дотоодын зах зээл дэх өрсөлдөөний нөхцөл байдлын талаарх үзэл бодол
- Өрсөлдөгчдийн талаарх тодорхойлолт, ХЕС-ийн дагуу гаалийн татвараас чөлөөлөгдж буй импортын бараа бүтээгдэхүүний өрсөлдөөнд үзүүлэх нөлөөлийн талаарх шинжилгээ судалгаа болон нэрийнх нь өмнөөс хүсэлт гаргаж буй бизнесийн үйл ажиллагааны төрөл
- 1974 оны Худалдааны тухай хуулийн 5-р хэсгийн нэмэлт, өөрчлөлт оруулсан 501 ба 502(с) заалтуудад дурдсан гадаадын зах зээл дэх худалдаанд тавигддаг тарифийн болон тарифийн бус хориг арга хэмжээ зэрэг хүчин зүйлстэй холбоотой мэдээлэл
- ХЕС-ийн тухай асуудал хариуцсан дэд хорооноос шаардаж болох бусад төрлийн холбогдох мэдээлэл.

b. Зарим нэр төрлийн бараа бүтээгдэхүүнийг жагсаалтад шинээр оруулах, эсвэл өрсөлдөөнт хэрэгцээний хязгаарлалтаас чөлөөлөгдөх хүсэлт гаргах

АНУ-ын холбогдох аж үйлдвэрийн салбарын талаарх хуанлийн сүүлийн гурван жилийн дараахь төрлийн мэдээллийг нэрийнх нь өмнөөс хүсэлт гаргасан ашиг хүртэгч хөгжиж буй орны болон боломжтой нөхцөлд ашиг хүртэгч хөгжиж буй орны гол нийлүүлэгчдийн хувьд гарган өгөх хэрэгтэй. Үүнд:

- Ашиг хүртэгч хөгжиж буй орны, ХЕС-д нэмэлт, өөрчлөлт оруулснаас ашиг хүртэж болох гол нийлүүлэгчдийн талаарх тодорхойлолт
- Пүүсүүдийн тоо болон байршил

- Бодит үйлдвэрлэлтэй холбоотой мэдээлэл болон ХЕС-д хамрагдсан тохиолдолд бодит үйлдвэрлэлд гарах өсөлтийн хувь хэмжээний тооцоо
- Үйлдвэрлэлийн бодит хүчин чадал ба уг хүчин чадлын бодит ашиглалт болон ХЕС-д хамрагдсан тохиолдолд тэдгээрт гарах өсөлтийн хувь хэмжээний тооцоо
- Ажиллагдын тоо, төрөл, цалин хөлсний хэмжээ, байршил болон эдгээр бүх мэдээлэлд гарсан өөрчлөлтүүд зэрэг хөдөлмөр эрхлэлттэй холбоотой мэдээлэл, түүнчлэн ХЕС-д хамрагдсан тохиолдолд тэдгээрт гарах өсөлтийн хувь хэмжээний тооцоо
- Тoo хэмжээ, өртөг ба үнэ зэрэг нийт борлуулалттай холбоотой тоон мэдээлэл (тоо хэмжээ, өртөг ба үнэ)
- Гол зах зээлүүд, бүтээгдэхүүний хуваарилалт, дээрх зах зээлүүд дэх тарифийн хөнгөлөлт, чөлөөлөлт, бүтээгдэхүүний тоо хэмжээ ба өртөг болон экспортод гарч буй хандлагууд зэрэг нийт экспорттой холбоотой мэдээлэл
- Бүтээгдэхүүний тоо хэмжээ, өртөг ба үнэ, түүнчлэн эдгээр бүтээгдэхүүний экспортын өрсөлдөх чадварт нөлөөлж буй хүчин зүйлсийг ашиг хүртэгч хөгжиж буй бусад орнуудын ижил төстэй буюу үүд өрсөлдөхүйц бараа бүтээгдэхүүнтэй харьцуулсан судалгаа зэрэг тухайн нэр төрлийн бүтээгдэхүүний АНУ руу чиглэсэн экспорттой холбоотой мэдээлэл. Өгч буй материалынхаа хаа боломжтой хэсэгт нь ашиг хүртэгч хөгжиж буй орнуудын аж үйлдвэрийн салбарын хөгжил болон үйлдвэрлэлд гарч буй хандлагуудтай холбоотой мэдээллийг оруулах шаардлагатай.
- Бараа материалын, хөдөлмөрийн болон нэмэгдэл зардал зэрэг зардлуудын шинжилгээ
- Тухайн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж буй пүүсүүдийн ашигт ажиллагааны түвшин
- Чанарын өөрчлөлт буюу үнийн өрсөлдөөнд нөлөөлөх хэрэглээнд өгч буй үнэлгээ
- Хүсэлт гаргаж нь гадаад улсын засгийн газар, эсвэл төрийн хяналтад байдаг аж ахуйн нэгж байгаа тохиолдолд өөрчлүүлэхийг хүсч буй нөхцөл байдал нь хүсэлт гаргаж буй тухайн орны эдийн засгийн хөгжилд хэрхэн түлхэц үзүүлэх тухай мэдээлэл
- ХЕС-д заасан 35%-ийн нэмэгдсэн өртгийн шаардлагыг тухайн нэр төрлийн бүтээгдэхүүн хэрхэн биелүүлэх талаарх
- ХЕС-ийн тухай асуудал хариуцсан дэд хорооноос шаардаж болох бусад төрлийн холбогдох мэдээлэл.

c. Улс орны практиктай холбоотой хүсэлтийн талаарх товч мэдээлэл

Холбогдох АХХБО буюу НБХАХХБО-ны талаарх хамгийн багаар бodoход дараах төрлийн мэдээллийг гарган өгөх хэрэгтэй. Үүнд:

- Хүсэлт гаргаж буй хувь хүн буюу сонирхогч талын нэр, хаяг, утас,

факсийн дугаар болон и-мэйлийн хаяг.

- **Хүсэлт:** ХЕС-ийн дагуу олгогдсон, ХЕС-д хамрагдах бараа бүтээгдэхүүний гаалийн татвараас чөлөөлөгдхөн нөхцлийг (эдгээрийн аль нэг нь байх) цуцлах, хойшлуулах, эсвэл БУС-ийн тохирох дугаарыг тусган тухайн орноос Америкийн Нэгдсэн Улсад оруулж буй импортын төрөл хэлбэртэй холбогдуулан гаалийн татвараас чөлөөлөгдөх арга хэмжээний хэрэгжилтэд тодорхой хязгаарлалт тавиулах зэрэг хүсэлт.
- Тухайн орны практикт шалгалт хийх хүсэлт гаргахад нөлөөлсөн тодорхой хүчин зүйлс. Эдгээр хүчин зүйлсийг дүрмийн 19-р хэсгийн 5-р бүлгийн 2561 дэх хэсэг болон 2462 дахь хэсгийн (с) дэд хэсэгт жагсааж бичсэн болно.
- Хүсэлтийг дагалдах бусад мэдээллийн хамт хүлээн авсан тохиолдолд тухайн ашиг хүртэгч хөгжиж буй орны статуст шалгалт хийж, тодорхой нөхцөл бүрдсэн бол түүнийг өөрчлөх болсон шалтгааныг тайлбарласан бичиг.
- Тухайн хүсэлтийн гол агуулгыг өмнө нь гаргасан хүсэлтийн дагуу хянан үзсэн бол уг хүсэлтэд хүсэлт тавьж буй асуудлыг цаашид хянан хэлэлцэх нөхцлийг бүрдүүлэхүйц хангалттай шинэ мэдээллийг тусгасан байх ёстой.

Олон нийтэд түгээх болон бизнесийн нууцтай холбоотой мэдээллийн хувилбарууд

Хүсэлт болон гарган өгсөн бусад баримт бичигт бизнесийн нууцтай холбоотой мэдээлэл байгаа бол нууц мэдээллийг шаардлагатай хэсэгт нь хасч завсарласан гэдгийг тэмдэглэсэн нууц бус хувилбарыг эх баримт бичигтэй нь хамт гарган өгөх хэрэгтэй.

Жишээ нь, хүсэлт гаргагчийн зүгээс “ХЕС-д хамрагдсан эх үүсвэрээс доогуур үнэ бүхий хувцасны гоёл импортлогдоноос болж 2001 онд Интернэшил Уижетс компани 20 сая долларын алдагдал хүлээнээс гадна үйлдвэрлэлийн хүчин чадлаа 30%-иар бууруулахаас өөр аргагүй байдалд орсон” гэдгийг мэдээлэх хүсэлтэй байна гэж төсөөлөө. Хэрэв дээрх өгүүлбэрт орсон мэдээлэл бизнесийн нууцтай холбоотой байгаа бол бизнесийн нууцтай холбоотой мэдээллийн хувилбарт тэдгээрийг дараахь байдлаар том хаалтад хийж тэмдэглэнэ: “ХЕС-д хамрагдсан эх үүсвэрээс доогуур үнэ бүхий хувцасны гоёл имортлогдоноос болж 2001 онд Интернэшил Уижетс компани [20 сая долларын] алдагдал хүлээнээс гадна [үйлдвэрлэлийн хүчин чадлаа 30%-иар бууруулахаас] өөр аргагүй байдалд орсон”. Гэсэн хэдий ч олон нийтэд зориулсан мэдээллийн хувилбарт энэ нь дараах байдлаар уншигдана: “ХЕС-д хамрагдсан эх үүсвэрээс доогуур үнэ бүхий хувцасны гоёл имортлогдоноос болж 2001 онд Интернэшил Уижетс компани [***] алдагдал хүлээнээс гадна [***] өөр аргагүй байдалд орсон”. Гагцхүү хүсэлт гаргагч л чухам ямар мэдээллийг олон нийтэд хүргэж болох болон алийг нь бизнесийн нууц мэдээлэлд тооцохыг тодорхойлох ёстой.

Нууц мэдээлэл бүхий хувилбарын хуудас бүрийн дээд ба доод захад “БИЗНЕСИЙН НУУЦ” гэсэн тод харагдахуйц тэмдэглэгээг тавих бөгөөд олон нийтэд түгээж болох хувилбарт “ОЛОН НИЙТЭД ЗОРИУЛСАН ХУВИЛБАР”, “НУУЦ БУС” 2-ын аль нэгийг тод харагдахуйц байдлаар бичиэ. Хүсэлт гаргагч хоёр хувилбарыг хоёуланг нь гарган өгөх боловч зөвхөн олон нийтэд зориулсан хувилбарыг л АНУХТГ-ын нийтийн уншлагын танхимд тавина.

Хүсэлтийг хэрхэн гарган өгөх талаар

Хүсэлтийг богино хугацаанд цаг алдалгүй хүлээн авах үүднээс ХЕС-ийн тухай асуудал хариуцсан дэд хороо нь ХЕС-ийн шалгалтын хариу болгон өгсөн материалыг зөвхөн электрон хэлбэрээр цахим шуудангаар дамжуулж авдаг. Материалыг гараас гарч өгөх буюу срдийн шуудангаар илгээсэн бол хүлээн авахгүй. Хүсэлтийг илгээх цахим шуудангийн хаягийг Холбооны бүртгэлийн холбогдох мэдэгдэлд бичсэн байгаа.

Өгч буй материал нь Англи хэл дээр бичсэн нэг эх хувь байх ёстой бөгөөд Холбооны бүртгэлд дурдсан хоорондоо хамгийн бага зйтай байх мөрүүд бүхий хуудасны тооноос хэтэрсэн хэмжээтэй байж болохгүй.

Цахим шуудангаар илгээх захидалын гарчиг нь Холбооны бүртгэлийн холбогдох мэдэгдэлд дурдсантай дүйж байх ёстой (жишээ нь “ХЕС-ийн дагуу хийх улс орны практикийн шалгалт гэх мэт”) бөгөөд түүний ард хэргийн дугаар болон тухайн улсын нэр (мөн л Холбооны бүртгэлийн холбогдох мэдэгдэлд дурдсантай дүйж байх ёстой), түүнчлэн тохиромжтой бол “Хүсэлт”, “Бичгээр гарган өгсөн санал”, “Шалгуулах хүсэлтээ илрэхийлэх тухай”, “Хянан хэлэлцэхээс өмнөх шатны товч мэдээлэл”, эсвэл “Хянан хэлэлцсэний дараахь шатны товч мэдээлэл” зэргийн аль нэгийг бичсэн байна. (Жишээ нь цахим захидалын гарчиг нь “ХЕС-ийн дагуу хийх улс орны практикийн шалгалт, 001-CP-02, Бангладеш, Хянан хэлэлцэхээс өмнөх шатны товч мэдээлэл.” гэсэн байж болно).

Баримт бичгийг (“.DOC”), эсвэл текст хэлбэрээр (“.TXT”) өргөтгөлтэйгээр илгээх ёстой. Хэмжээ нь дэндүү том байдаг болон ХЕС-ийн тухай асуудал хариуцсан дэд хорооны цахим шуудангаар мэдээлэл дамжуулах болон хуваарилах ажиллагаанд саад учруулж болох учраас баримт бичгийг цахим дурс буюу зураг хэлбэрээр (жишээ нь “.JPG”, “.PDF”, “.BMP”, эсвэл “.GIF” зэрэг өргөтгөлтэйгээр) илгээж болохгүй. Дээрх төрлийн өргөтгөл бүхий баримт бичиг агуулсан захидалыг олонх тохиолдолд хүлээж авдаггүй. Тоо баримт бүхий дагалдах бичиг баримтыг Excel файл хэлбэрээр, 8 ½ x 11 инчийн хэмжээтэй цаасан дээр хэвлэж гаргах боломжтой байдлаар илгээж болно. Хоорондоо холилдож будилуулах болон бичиг баримтууд ХЕС-ийн тухай асуудал хариуцсан дэд хороо руу саадгүй очих, мөн уг хүсэлтэд буй

мэдээллийг тус дэд хороо бүрэн дүүрэн хянан үзэх боломжийг бүрдүүлэх үүдиэс хүсэлтэд хавсаргах нэмэлт мэдээллийг боломжтой бол тус тусдаа бус, нэг захидлаар илгээх нь зүйтэй.

МЭДЭЭЛЛИЙН БУСАД ЭХ СУРВАЛЖУУД

Америкийн Нэгдсэн Улсын Барааны Уялдуулсан Систем

АНУ-ын тарифийн хуваарийг дотор нь бараа бүтээгдэхүүний төрлөөр нь 100 орчим бүлэгт хуваан авч үздэг. Хэрэв Та өөрийн бүтээгдэхүүний тарифийн дугаарыг мэдэхгүй байгаа бол АНУ-ын Олон улсын худалдааны комиссийн тарифийн дугаарыг шуурхай харах

http://dataweb.usitc.gov/scripts/gsp/gsp_tariff.asp гэсэн сайт, эсвэл Гаалийн холбогдолтой дүрэм, журмын <http://rulings.cbp.gov> хаягтай сайтаас түүнийг олж болно. Хэрэвзээ Та өөрийн бүтээгдэхүүний нэр төрөлд тохирох БУС-ийн дэд гарчиг буюу кодын дугаарыг бэлхнээ мэдэж байгаа бол тухайн дэд гарчигийн дугаарын эхний хоёр тоогоор илэрхийлэгдсэн бүлгийн дугаар руу очиж болох юм. Жишээ нь БУС-ийн дэд гарчиг нь 1604.30.20 байх түрсний тухайд бол 16-р бүлэг рүү орж харах хэрэгтэй. БУС-ийн дэд гарчиг нь 0302.70.20 болох халим загасны түүхий түрстэй холбоотой мэдээллийг олохын тулд 3-р бүлэг рүү орох жишээтэй. Эдгээрийг үндэслэн Та Гаалийн албаны дүрэм, журам буй <http://rulings.cbp.gov> хуудас руу орж үзэж болно.

БУС-ийн дэд гарчигаар ХЕС-д хамрагдах тухай мэдээллийг Ашиг хүртэгч хөгжиж буй орны хувьд AA@ кодоор, нэн буурай хөгжилтэй ашиг хүртэгч хөгжиж буй орны хувьд AA+@ кодоор тус тус ASpecial@ гэсэн гарчигтай гаалийн татварын хувь хэмжээг бичсэн багананд үзэж болох юм. Жишээ нь 1604.30.20 дугаарын БУС-ийн дэд гарчигийн хувьд Special@ гэсэн гарчигтай гаалийн татварын хувь хэмжээг бичсэн багананд AA@ тэмдэглээ тавьж заасан байгаа учраас загасны түрс нь ХЕС-д хамрагдах бүтээгдэхүүн болно. Дээрх код байхгүй байвал тухайн бүтээгдэхүүн ХЕС-д хамрагдахгүй гэж ойлгох хэрэгтэй. Хэрэв AA*@ код байх аваас энэ нь тухайн иэр төрлийн бүтээгдэхүүний хувьд зарим орнууд ХЕС-д хамрагдахгүй гэсэн үг юм. Дээр дурдсанаар ХЕС-д хамрагдахгүй тохиолдлуудыг БУС-ийн эхэнд буй Ерөнхий тайлбарын GN 4(d) хуудаст тайлбарлан бичсэн байгаа.

Дотооды Аюулгүй Байдлын хамгаалах департамент: Гаалийн ба хилийн хамгаалалтын алба (Гаалийн алба)

(<http://www.cbp.gov/xp/cgov/import/>).

2001 оны 9-р сарын 11-нээс өмнө урьд нь АНУ-ын Гаалийн алба иэртэй асан байгууллагын гол үүрэг нь бүх нэмэлт, өөрчлөлтуүдийг тусгасан 1930 оны Тарифийн тухай хуулийг хэрэгжүүлэх явдал байсан. Тэр цагаас хойш Гаалийн албыг хил хамгаалалтын бусад албадтай нэгтгэж АНУ-ын Гаалийн ба хилийн хамгаалалтын албыг зохион байгуулсан юм. Чухамхүү энэ өөрчлөн зохион байгуулалт нь Гаалийн албаны удаан хугацааны туршид биелүүлж ирсэн олон улсын худалдааг хамгаалах болон хөнгөвчлөх чухал үүрэгтэй яв цав нийцсэн билээ. Олон улсын аялал жуулчлал болон худалдаатай холбоотой гаалийн татвар, хураамжийг үнэлж, хураах замаар

үндэсний орлогыг баталгаажуулах уламжлалт үүргээ Гаалийн алба авч үлдсэн юм. Цаашилбал, импортын бараа бүтээгдэхүүн хилээр оруулах үйл ажиллагаа явуулдаг хүмүүст дүрэм, журмын холбогдолтой зааварчилгаа өгөх замаар Гаалийн алба нь тэдгээрийг дотоодын хууль, дүрэм, зохицуулалтад нийцүүлэх ажлыг үр дүнтэйгээр зохион байгуулж байна.

Гаалийн алба нь <http://www.cbp.gov/xp/cgov/toolbox/forms/> вэб сайтаар дамжуулж гаалийн бүрдүүлэлт хийх боломжийг олгож байдаг. Түүнчлэн уг сайтад импортын үйл ажиллагаа, шаардлагын талаарх бүрэн дүүрэн мэдээллийг тавьсан буй. Дээрх мэдээлэлд бараа бүтээгдэхүүнийг хилээр оруулах, дүрэм, журамд нийцэж буй эсэх, нэхэмжлэх, гаалийн татварын хэмжээг үнэлж тогтоох, барааны ангилал, өртөг, тэмдэглэгээ болон тусгай шаардлагууд багтана. Гаалийн албанаас гаргадаг товхимлуудыг <http://www.cbp.gov/xp/cgov/toolbox/publications/> сайтаас, харин дүрэм, журмыг <http://rulings.cbp.gov> сайтаас тус тус үзэж болох юм.

Худалдааны холбогдолтой мэдээллийн эх суралж

АНУ-ын Олон улсын худалдааны комиссийн мэдээллийн вэб сайт (<http://dataweb.usitc.gov/>).

Үүнд орж мэдээлэл авахын тулд заавал бүртгүүлэх шаардлагатай. Энэхүү чухал сайт нь АНУ-ын импорт ба экспортын талаарх мэдээллийг БУС, Олон улсын худалдааны комисс, мэдээллийн төвийн зэрэг бүлэглэлүүдээр, бараа бүтээгдэхүүний нэр төрөл, улс (эсвэл EU-15 буюу ХЕС зэрэг бүлэг улсуудаар) болон шаардлагатай тохиолдолд тухайн бүтээгдэхүүн АНУ руу орсон буюу гарсан экспорт, импортын боомтоор хайж олж үзэх боломжийг олгодог. Мэдээ баримтыг жилээр, улирлаар болон сараар ангилан үзэж болно. 1989 оноос хамгийн сүүлийн сар хүртэлх хугацааны (ихэвчлэн одоогоос урагш 2 сараас өмнөх) мэдээллийг үзэх боломжтой юм. Мөн түүнд гадаадын олон улс орон болон тарифийн жагсаалтад холбосон холбоосууд бий.

Тооллогын Төвчөо (<http://www.census.gov/foreign-trade/statistics/index.html>)

Тооллогын товчооны Гадаад худалдааны хэлтсээс АНУ-ын бараа бүтээгдэхүүн ба үйлчилгээний олон улсын худалдааны тайлан гэх зэрэг чухал, олонд танигдсан мэдээллийг эрхлэн гаргадаг. Энэхүү сайтад зочилсноор Та импорт, экспортын холбогдолтой хамгийн сүүлийн үеийн статистик мэдээг худалдааны түнш болон Нэгдсэн Улсын муж улсуудаар олох боломжтой. Түүхчилсэн мэдээллийн эмхэтгэл 1960 оноос хойшиг тоо баримтыг агуулж буй.

АНУ-ын Хөгжлийн Агентлагийн Олон улсын хөдөөг аж ахуйн

алба (<http://www.fas.usda.gov/markettradedata.asp>)

ХЕС-ийн дагуу АНУ-ын хийж буй худалдааны 5-10% нь хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүнийх байдаг. Дэлхийн бараг улс бүрт байдаг АНУ-ын элчин сайдын яамдын олонхид нь төлөөлөгчөө суулгадаг Олон улсын хөдөө аж ахуйн албанад хандаж нөөц баялгийн талаарх статистик тоо баримт, судалгаа шинжилгээний тайлан болон ХЕС-д хамрагддаг орнууд дахь тус салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл болон худалдааны талаарх бусад мэдээллийг үзэж болно.